

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2017 он**

ГАРЧИГ

1.	ТАНИЛЦУУЛГА	3 хуудас
2.	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН	4 хуудас
3.	ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ	4 хуудас
4.	ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	4-27 хуудас
5.	ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ	27 хуудас
6.	ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ	27 хуудас

ТАНИЛЦУУЛГА

Тайлант хугацаанд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг, Аялал жуулчлалын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжтой уялдуулан үйл ажиллагаагаа явуулж, Засаг даргад нийлүүлэх нийт 22 үүнээс тусгай захиалгат 16 бүтээгдэхүүн ажил үйлчилгээ, газрын дүрмээр хүлээсэн болон Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, үр дүнг тайланд тусгав.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

А/. Монгол Улсын Үндэний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилтийг 9 чиглэлээр гаргаж тайлагнав.

Б/. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 4 зорилт, 6 арга хэмжээний хэрэгжилт 95%

В/. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Авто замын газартай хамтран ХУД-ийн 11-р хороо Зайсан толгойн баруун тал буюу Сарнайх дэлгүүрийн уулзвараас Богд уулын Зайсангийн ам, Богд хан амралтын газар хүртэл 2.5 км урт, 7 м өргөн зорчих хэсэгтэй, зүүн талдаа 2.25 м өргөн явган замтай, баруун талдаа 2.25 м өргөн дугуйн замтай, иж бүрэн гэрэлтүүлэгтэй, борооны ус зайлуулах шугамтай 264 авто машины зогсоол барьж ашиглалтад оруулав. Хэрэгжилт 100%

Г/. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр -73%

Соёлын үйлдвэрлэл үндэсний хөтөлбөрийн 2 заалт - 90%

-МУ-ыг гадаадад сурталчлах хөтөлбөрийн төлөвлөгөөний 11 заалтын хэрэгжилт -81%

Д/. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 9 заалт -92%,

Д/. Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 7 заалтын хэрэгжилт -94%

Е/. “Улаанбаатар хотын аялал жуулчлалыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн төслийг 2017 оны 06 сарын 15-ны өдөр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, НИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр, өргөн барив.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

А/. -Монгол Улсын Засгийн газрын тогтоолын хэрэгжилт 90%

- Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 100%

- Монгол улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврын 11 заалт 95%

- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийн 1 заалтын хэрэгжилт 50%

- НИТХ-ын тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолын хэрэгжилт 90 %,

- НИТХ-ын 2017 оны тогтоолын биелэлт 90 %

- Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт 90%

- Нийслэлийн Засаг даргын албан даалгаврын хэрэгжилт 90%

- Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн анхдугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт 99%

Б/. Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/01 дүгээр захирамжаар 2017 оныг “Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жил болгон зарласантай холбогдуулан А/54 дүгээр захирамжаар баталсан төлөвлөгөөний заалтын хэрэгжилт 88%.

В/. Аялал жуулчлалын салбарт мөрдөгдөж байгаа стандартуудыг шинэчлэх, олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах ажлын хүрээнд Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008 стандартыг шинэчлэн, төслийг Стандартчилал хэмжил зүйн газрын Стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлж 2017 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр батлуулав.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

А/. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ:

1. Аялал жуулчлалын байгууллага болон жуулчдад үйлчлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:

➤ Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын хэрэгжилтийг хангах, үйлчилгээг сайжруулах, шуурхай болгох зорилгоор даргын зөвлөлийн хурлаар уг асуудлыг хэлэлцэн албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, үйлчилгээний хүсэлтийг түргэн, шуурхай хүргэх үүднээс уг асуудлыг хавсран хариуцдаг 2 ажилтан нэмж 3 болгон нэмэгдүүлсэн. Эдгээр албан хаагчид баг болон хамтран Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын стандартын хэрэгжилтэд гол анхаарлаа хандуулан ажилласан. Иргэд, ААН-ээс зочид буудал, дэн буудал, амралтын газрын зөвшөөрөл хүссэн өргөдлийн дагуу ажлын хэсэг стандартын үзлэг шалгалтыг санал хүсэлт ирснээс хойш 9 хоногт багтаан шийдвэрлэхийг гол зорилтоо болгов. Байгууллагын хурлыг сард 2 удаа тогтмол зохион байгуулж иргэд, ААНБ-уудаас ирсэн санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн явцын мэдээллийг танилцуулж хяналт тавин ажиллаж байна. 2017 оны байдлаар хугацаа хоцорч шийдвэрлэсэн санал, хүсэлт байхгүй байна. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авч, олгож ажиллаж байна. Иргэн, ААНБ-уудын хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна. Тогтоолын хэрэгжилт 90%-тай байна.

Зөвшөөрөл авсан байгууллагын тоог сүүлийн 4 жилээр үзүүлбэл:



2. Жуулчдыг татах болон аялал жуулчлалын салбарын нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөллийг зохистой түвшинд хүргэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах ажлын хүрээнд:

➤ “Улаанбаатарын өвлийн наадам 2017” арга хэмжээ зохион байгуулав. Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/36 дугаар захирамжаар 02-р сарын 11,12-ны өдрүүдэд “Улаанбаатарын өвлийн наадам 2017” арга хэмжээг НЗДТГ, НОБГ, НСУГ, БТСХ, БЗД-ын ЗДТГ, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨҮГ, “Улаанбаатар чуулга”, Хот тохижилтын газар, Мөсөн шагайн холбоо, Мөсөн сурын холбоо, Мэргэжлийн сноубордын холбоо, Регбигийн холбоо, Цанын холбоо, “Зайсан мото” клуб, Үндэсний хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний нэгдсэн холбоо зэрэг 16 байгууллагуудтай хамтран Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр Мөсөн сурын харвааны улсын аварга шалгаруулах тэмцээн, Регбигийн Улаанбаатарын цомын аварга шалгаруулах тэмцээн, Цанын үйлчилгээ, цанын сонирхогчийн тэмцээн, Спортын буухиа тэмцээн, Мөсний шагайн харвааны тэмцээн, Мөсөн хананы авиралтын үзүүлбэр, тэмцээн, Мөсөн шатрын тэмцээн, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн 20 гаруй хорооны иргэдийн үндэсний хувцастай парад зэрэг арга хэмжээг зохион байгуулав. Арга хэмжээний төрлүүдээр 1-3 дугаар байр эзлүүлэн идэвхтэй оролцсон иргэн байгууллага тус бүрийг шагнаан урамшуулж, зохион байгуулалтын ажилд нийт 51.236.000 төгрөгийг төсөвлөн зарцуулж, 18.986 төгрөг хэмнэсэн байна. Энэ жилийн арга хэмжээг иргэдийн баяр болгон, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохиогдсон нь иргэд, оролцогчдын хувьд тав тухтай мөн хотын төвд ойр байсан нь хамрагдах иргэдийн тоо нэмэгдэхэд нөлөөллөө. Өмнөх жилүүдээс үйл ажиллагааны төрөл, хэлбэрүүд нэмэгдсэн. Иргэд, гэр бүлийн дунд спортын буухиа болон олс таталтын тэмцээн зохион байгуулсан нь өвлийн наадмыг зорин ирэх иргэд, наадмын цар хүрээг нэмэгдүүлэхэд нөлөөллөө. Дашваанжил ХХК-ийн зүгээс

санаачлага гаргаж талбай, тайз, асар гэрүүдэд халаагуур тавьж хамтран ажиллав. Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн улирлын уламжлалт болон орчин үеийн экстрим спортыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах, өвлийн улиралд Улаанбаатар хотод ирсэн жуулчдын сонирхлыг татах арга хэмжээний тоог нэмэгдүүлэх зорилготой уг арга хэмжээнд өмнөх жилүүдээс оролцогч, сонирхогчдын тоог нэмэгдүүлэв. Уг арга хэмжээг 2016 онд 1 өдөр, 9 төрлөөр, 3000 гаруй хүн оролцож байсан бол 2017 онд 2 өдөр, 18 төрлөөр зохион байгуулж, 10.000 гаруй хүн үзэж сонирхон. Арга хэмжээнд 60.000.000 төг төсөвлөснөөс 51.236.0 төгрөгийг зарцуулж 18.986 төгрөг хэмнэсэн.

➤ “Дээлтэй Монгол Наадам” арга хэмжээг зохион байгуулав.

Үндэсний их баяр наадмын хөтөлбөрт багтсан “Дээлтэй Монгол Наадам-2017” арга хэмжээг 07-р сарын 10-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. Арга хэмжээг Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны зардлаар нийт 20 000 000 төгрөгийн төсөвтэйгөөр зохион байгуулж, ерөнхий ивээн тэтгэгчээр “АПУ” ХХК, “Батзүү” ХХК, Монголын Аялал жуулчлалын холбоо, мэдээллийн ивээн тэтгэгчээр “UBS” телевиз ажиллаж, Үндэсний хувцастай иргэдийн баярын жагсаал, “Монгол костюмс”, “Шилмэл загвар” ХХК-ийн Монгол хаад, хатдын үндэсний хувцасны орчин үеийн загварын үзүүлбэр, урлагын тоглолт, “Амин тоонто” төрийн бус байгууллага иргэдтэй хамтран ёохор хатирч “Алтай” хамтлаг урлагийн тоглолтоо толилуулснаас гадна иргэдийн дунд “Хүннү”-гийн үеийн дэвсэх бүжгийг зохион байгуулав. Анх 2006 онд 200 үндэсний хувцастай оролцогчтойгоор зохион байгуулагдаж байсан энэхүү наадам энэ жил 11 жилдээ зохион байгуулагдаж 10.000 мянган хүн оролцсон бол өнгөрсөн жил 5000 гаруй хүн, 300 гаруй гадаадын жуулчид үзэж 39.400.000 төг зарцуулсан байна. Өмнөх жилүүдэд наадамд хүрэлцэн ирсэн иргэд үзээд буцдаг байсан бол энэ жил өөрсдийг нь оролцуулсан арга хэмжээг түлхүү зохион байгуулсан нь оновчтой болж, иргэд, жуулчдын сэтгэлд хүрэв.

➤ “Даншиг наадам-Хүрээ цам” наадмын үеэр үзэсгэлэн зохион байгуулав.

Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/574 дугаар захирамжийн дагуу “Даншиг наадам-Хүрээ цам” наадмыг 2017 оны 08 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд “Төв цэнгэлдэх хүрээлэн”-д зохион байгуулав. Арга хэмжээний үеэр тус газраас Шашин соёлын эд зүйлсийн үзэсгэлэн зохион байгуулав. Нийт 25 асарт 38 иргэн, аж ахуйн нэгж оролцсоноос 33 нь үндэсний хувцас, гоёл чимэглэл, малгай, бэлэг дурсгал зэрэг худалдаа үйлчилгээ гаргасан ба 5 асарт Их Майдар төсөл, Хөдөө гэр төсөл, Нийслэл гайд сэтгүүл зэрэг аялал жуулчлалын төсөл хөтөлбөрүүд үзэсгэлэн гаргав. Жуулчид цамын маск, каллиграф, гоёл чимэглэл зэрэг бэлэг дурсгалын зүйлүүдийг ихээр сонирхож байсан байлаа. Мөн “Даншиг наадам-Хүрээ цам” наадмын үеэр Даншиг наадмыг зохион байгуулах ажлын хэсэгт хүсэлт гаргасны дагуу 1, 2, 3, 4 дүгээр секцүүдийн нийт 2315 суудлыг жуулчдад хувиаралж, аялал жуулчлалын байгууллагуудад тарааж 46 тур оператор, 52 иргэнд нийт 1378 билетийг тараав. Үүнээс 750 орчим нь гадаадын жуулчид үзэж сонирхов. Тус газрын ажилтнууд 2 өдрийн турш жуулчдын 4 хаалга дээр ажиллав.

➤ “Олон үндэстний хоолны гудамж” арга хэмжээ зохион байгуулав.

Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/636 дугаар захирамжийн дагуу “Олон үндэстний хоолны гудамж” арга хэмжээг 2017 оны 09 дүгээр сарын 02,03-ны өдрүүдэд “Шөнийн гэрэлт гудамж”-нд зохион байгуулав. Арга хэмжээг Ажлын хэсгээс баталсан удирдамжийн дагуу төлөвлөгөө гарган ажиллав. Арга хэмжээнд уг гудамжинд үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний газрууд дээр нэмж шаардлага хангасан 19 аж ахуйн нэгжийг бүртгэн авч, талбай хуваарилан, иргэдэд олон нэр төрлийн хоол бүтээгдэхүүнээр хямдралтай үнээр худалдаалж ажиллав. Арга хэмжээний үеэр Улаанбаатар чуулгын урлагийн тоглолт, “Монголын хоол урлахуйн нийгэмлэг”-ийн тогоочдын хоолны үзүүлбэр, “Бартендер” шоу, “Косплей” шоу, “Ди-жи” шоу, “Салса” бүжгийн үзүүлбэр, “Сей битбокс крү” битбокс үзүүлбэр, “Натур дэнс продакшн” “Хулиганз” хамтлагуудын бүжгийн үзүүлбэр, “Кэй-Эм” энтертайнмент флашмоб, “Саксофончин Сүх” хөгжмийн тоглолт, “UB JAZZ”, “Компасс” хамтлагуудын тоглолт, Ковер дууны тэмцээний оролцогчдын тоглолтыг 2 өдрийн турш зохион байгуулав.

➤ “Шөнийн гэрэлт гудамж” төсөл хэрэгжүүлэв.

Улаанбаатар хотыг олон улсад өрсөлдөх чадвартай, зүүн хойд Азийн бизнес, соёлын болон дамжин өнгөрөх жуулчлалын төв болгон, ирсэн жуулчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрөөх аялал жуулчлалын олон талт үйлчилгээ бий болгох зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/496 дугаар захирамжийн дагуу “Шөнийн гэрэлт гудамж” төслийн төлөвлөлтийн зураг, төслийг НХТЕТГ, төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан ажиллах менежментийн багийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах ажлыг НСУГ, худалдаа, үйлчилгээнд, хяналт тавих ажлыг НМХГ гүйцэтгэн, төслийг хэрэгжүүлэгч байгууллагаар Юнайтед Инвестмент партнерс ХХК ажиллав. Тус газар Шөнийн гэрэлт гудамжинд асар болон зориулалтын бусад түр байгууламжаар худалдаа, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгжүүд, хоол үйлдвэрлэл үйлчилгээ, хүнсний худалдаа эрхлэх, бэлэг дурсгал, гар урлалын үндэсний брэнд бүтээгдэхүүний худалдаа эрхлэх чиглэлээр аж ахуйн нэгжүүдийн сонгон шалгаруулалтын ажилд оролцож, гудамжны өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан ажиллах менежментийн багт, дэмжлэг, тусалцаа үзүүлж хамтран ажиллав. Шөнийн гэрэлт гудамж 2017 оны 06 сарын 08-ны өдөр нээлтээ хийж, 09 дүгээр сарын 30-ны өдөр хааж, долоо хоногийн баасан, бямба, нам гаригуудад 20:00 цагаас 05:00 цаг хүртэлх хугацаанд үйл ажиллагаа явуулж, давхардсан тоогоор 1.024.000 хүн ирсэн. Үүнээс 65 мянга гаруй нь гадаадын иргэд, жуулчид байлаа. Тус газрын зүгээс Шөнийн гэрэлт гудамж төслийн хүрээнд Гэр мэдээллийн төвийг шинээр нээж, тохижуулан, мэдээллийн ажилтанг 2 ээлжээр ажиллуулав. Уг мэдээллийн төвөөр 20.000 гаруй гадаад, дотоодын иргэд, жуулчдад үйлчилгээ үзүүлэв.

➤ “Нүүдэлчдийн амьдралаас орчин үеийн Улаанбаатар хот” үзэсгэлэн зохион байгуулав.

2017 оны 05 сарын 04-ний өдөр “Шангри-ла Улаанбаатар” зочид буудлын лобби танхимд зохион байгуулагдсан “Хотын хөгжил-шинжлэх ухаан, технологи” сэдэвт олон улсын бага хурлын үеэр аялал жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулав. Үзэсгэлэнд орчин үеийн техник, технологийг ашиглан Нүүдэлчдийн амьдралаас орчин үеийн Улаанбаатар хот үүссэн хөгжил, түүхийг харуулсан 4x8 метрийн хэмжээтэй номын модел бүхий 3 минутын видеог 3D прожектороор үзүүлэв. Монголчуудын зан заншлыг сурталчлах, таниулах зорилгоор монгол гэрийг иж бүрэн тавилгын хамт дэлгэн тавьсан. Монгол гэрт нийслэлийн “Улаанбаатар чуулга”-ын уран бүтээлчид урлагийн тоглолт хийв. Үзэсгэлэнгийн үеэр Улаанбаатар хотод хэрэгжиж байгаа томоохон төсөл, хөтөлбөр болох “Их майдар”, “Зайсан хилл”, “Түмэн хишигт” төслийн танилцуулгыг хийж, Монголын урчуудын эвлэлийн холбооны шилдэг уран бүтээлчдийн бүтээлээр уран зургийн үзэсгэлэн гаргав.

➤ “Талын түмэн адуу” арга хэмжээг гадаад оронд сурталчлав.

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 11 сарын 06-ны өдрийн А/829 дугаар захирамжын дагуу өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилготой “Талын түмэн адуу” арга хэмжээний зохион байгуулалтын хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлал, хот орчмын өвлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах БНХАУ-ын Одон телевиз болон Шилийн гол аймгийн төв телевизүүдийн найруулагчид, сэтгүүлчид, Шилийн гол аймгийн Гэрэл зургийн холбооны ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгч, ӨМӨЗО-ны гэрэл зургийн холбооны дарга нараас бүрдсэн 15 хүний бүрэлдэхүүнтэй багийг Улаанбаатар хотод ажиллахад шаардагдах төсвийг батлуулж, дэмжлэг үзүүлэн ажиллав. Мөн уг арга хэмжээний мэдээ мэдээллийг байгууллагын мэдээллийн сувгуудаар тогтмол сурталчлан ажиллав.

➤ “Монгол-Хятадын аялал жуулчлалын өдөрлөг” арга хэмжээ зохион байгуулав.

Өдөрлөгийг 7-р сарын 23-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулав. Өдөрлөгийн үеэр “Монгол-Хятадын Цайны замын ОУ-ын аялал жуулчлалын форум, “Энх тайван, Найрамдал, Залуу элч” Монгол-Хятадын өсвөр насны төлөөлөгчдийн Монгол улс дахь зуслангийн нээлтийн ажиллагаа, Монголын хүүхдийн ордны 40 хүүхэд, БНХАУ-ын ӨМӨЗО-ны 90 хүүхдийн хамтарсан урлагийн тоглолт боллоо.

3. Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийгэм, соёлын нөлөөллийг зохистой түвшинд хүргэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах ажлын хүрээнд:

➤ Явган аяллын зам тохижуулав.

БНСУ-ын Чөжү хотын Аялал жуулчлалын газартай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу БЗД-ийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт явган аяллын 14км зам, Налайх дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт явган аяллын 11км замд нийт 120ш туузтай багана, эхлэл төгсгөл цэг дээр морь хэлбэрт 8 тэмдэг, 2.2 өндөртэй том самбар 2-ыг тус тус байрлуулж тохижуулан Богдхан уулын ДЦГ, болон Горхи Тэрэлжийн Байгалийн цогцолборт газарт тус тус хүлээлгэн өгөв. Хүлээлгэн өгөх арга хэмжээнд Нийслэлийн Байгаль орчны газар, Богдхан уулын Дархан Цаазат Газрын хамгаалалтын захиргаа, Богдхан уулын болон Горхи Тэрэлжийн Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, “UB hiking” аяллын клуб, БНСУ-ын Жежу хотын Аялал жуулчлалын газрын дэд дарга Чой Каб Еол, Жежу Оллэ нийгэмлэгийг үүсгэн байгуулагч Сук Мёнг Соок, Монгол суугаа БНСУ-ын элчин сайд У Сун, нэгдүгээр нарийн бичгийн дарга Чон Ги Вон, Жежу Оллэгийн багийн төлөөлөл, эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах сайн дурын баг, алхагч аялагчид нийт 400 гаруй хүн оролцлоо. Арга хэмжээнд оролцсон төлөөллүүд Монголд нээгдэж буй Оллэ явган аяллын замын талаар мэдээлэл өгч, аялагчидтай хамт Хонхор тосгоноос Туул зөрлөгийн айлууд хүртэл алхаж аялагчдын аюулгүй байдал, тав тухыг хангах зорилгоор замд зөөврийн бие засах газар, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэв. Мөн аяллын эрүүл мэндийн сайн дурын баг 06 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд Хонхор тосгоны иргэдийг эрүүл мэндийн үнэгүй үзлэгт хамрууллаа. Нээлтийн арга хэмжээний дараа Монголд нээгдэж буй Оллэ явган аяллын замын тухай мэдээлэл өгөх хэвлэлийн бага хурлыг Холидэй Инн зочид буудалд хийж, хэвлэлийн бага хуралд БНСУ-аас ирсэн 3 телевиз, сонины сэтгүүлч, сайн дурын нийтлэлчид, Монголын хэвлэл мэдээллийн байгууллагууд, иргэдийн төлөөллүүд оролцлоо.

➤ Гэрлэх ёслолын ордонг хотын аяллын бүтээгдэхүүн болгов.

“Монгол хурим ёслол”-ын үйл ажиллагаа, хуримлах ёс заншилтай танилцах боломжийг нээж өгөх зорилгоор Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ-тай хамтарч ажиллах Санамж бичгийг 2017 оны 05 сарын 15-ны өдөр байгуулав. Санамж бичгийн хүрээнд 2017 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ-аас ирүүлсэн хөтөлбөрийн дагуу танилцуулга бэлтгэн аялал жуулчлалын компаниудад хүргүүлэн аяллын хөтөлбөрт оруулах, сурталчлах ажлыг хийж байна.

➤ Үндэсний өв соёл, уламжлалыг сурталчлахад дэмжлэг үзүүлэв.

Монголын үндэсний өв соёл, уламжлалыг гадаад сурталчлах зорилготой Монгол фильм группийн бүтээл Чингисийн хүүхдүүд уран сайхны киног жуулчны улирлын туршид “Corporate cinema” болон “Icinema” кино театраар өдөр бүр тодорхой цагуудад гаргаж жуулчдад үзүүлэх аяллын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болгон сурталчлах ажилд аялал жуулчлалын байгууллагуудын 60 гаруй төлөөллийг хамруулав.

➤ “Жуулчин” картыг үйлчилгээнд нэвтрүүлэв.

Жуулчдыг бэлэн мөнгөний эрсдэлээс хамгаалах, аюулгүй аялах нөхцөлийг бүрдүүлэх, Улаанбаатар хотын нийтийн тээврээр зорчих, үзвэр, үйлчилгээний газруудад багцын үнээр үйлчлүүлэх боломжтой “Жуулчин” картыг үйлчилгээнд нэвтрүүлэв. Энэхүү картыг Төрийн банктэй хамтран зах зээлд нэвтрүүлэх ажлын хүрээнд Модус Студиэр картын цогц дизайны ажлыг гүйцэтгүүлж, БНСУ-д хэвлүүлэн зах зээлд гаргав. 2017 онд энэ ажлыг үргэлжлүүлэн идэвхжүүлэх, сурталчлах зорилгоор Төрийн банкны сурталчилгаа, мэдээ мэдээлэл бүхий танилцуулгыг Ulaanbaatar official guide book гарын авлага номын 2 нүүрэнд, Улаанбаатар хотын албан ёсны газрын зурагт трэйвел картын борлуулах тус банкны салбаруудын мэдээллийг оруулах мөн Шөнийн гудамжны задгай театрт тус банкны трэйвел картыг сурталчилсан видео шторкийг хуваарийн дагуу цацах ажлуудыг хийж байна.

➤ Соёлын өвийг сэргээн хөгжүүлэх чиглэлээр Санамж бичиг байгуулав.

ЮНЕСКО-д бүртгэгдсэн Монголын казакуудын бүргэдээр ан хийх соёлын өвийг сэргээн хөгжүүлэх, гадаад дотоодод сурталчлах зорилгоор Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Бүргэдчдийн холбоо, Улаанбаатарын Аялал жуулчлалын холбоо хамтран “Нүүдэлчдийн өвөл” өвлийн аялал жуулчлалын арга хэмжээний хүрээнд “Бүргэдчдийн баяр”-ыг Улаанбаатар хотод тогтмол зохион байгуулахаар Санамж бичиг байгуулав.

➤ Явган аяллын замыг сурталчлах аялал зохион байгуулав.

Нийслэлийн Аялал жуулчлалын газраас санаачлан хот орчмын байгалийг танин мэдэх, явган аяллыг сурталчлах, бүх нийтийн биеийн тамирыг дэмжин, эрүүл амьдрахуйн хэв маяг бий болгох, аялагчдын тав тух, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн аяллын замыг тэмдэгжүүлэх, тохижуулах ажилд судалгаа хийх зорилготой явган аяллыг 2017 оны 07 дугаар сарын 02-нд зохион байгуулав. Уг явган аялалд Чингэлтэй дүүргийн 9,10-р хорооны 70 иргэн хамрагдаж, Чингэлтэй хайрханд аялах чиглэлийг тогтоох судалгааг хийлээ. Аялалд оролцсон 70 иргэн болон Чингэлтэй дүүргийн залуусын дунд “Чингэлтэй хайрхан” явган аяллын клубыг байгуулж, хорооны иргэдээс ахлагч нарыг томилов. Дүүргийн иргэд үүсгэн байгуулсан тус клубийг цаашид Нийслэлийн Аялал жуулчлалын газар дэмжин ажиллаж, улирал тутам аялал зохион байгуулан, аяллын талаарх боловсрол олгох, тодорхой сэдвийн хүрээнд сургалт хамтран зохион байгуулах, хэрэгцээт мэдээллээр хангахаар ажиллаж байна.

➤ Богд хан уулын Зайсан-Баруун Ширээт явган аялалын бүсэд авто зогсоолыг шинээр барив.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Авто замын газартай хамтран ХУД-ийн 11-р хороо Зайсан толгойн баруун тал буюу Сарнайх дэлгүүрийн уулзвараас Богд уулын Зайсангийн ам, Богд хан амралтын газар хүртэл 2.5 км урт, 7 м өргөн зорчих хэсэгтэй, зүүн талдаа 2.25 м өргөн явган замтай, баруун талдаа 2.25 м өргөн дугуйн замтай, иж бүрэн гэрэлтүүлэгтэй, борооны ус зайлуулах шугамтай 264 авто машины зогсоол барьж ашиглалтад оруулав.

➤ Чингэлтэй хайрханы нэгдүгээр явган аяллын чиглэлийг тохижуулж байна.

Богд ууланд алхалт хийж буй хүмүүсийн ачааллыг буруулах зорилгоор хот орчмын бусад хайрхануудад судалгаа явуулсан. 06 дугаар сарын 30-ны өдөр Чингэлтэй ууланд алхалт хийж, хүмүүсийн хамгийн их алхдаг Чингэлтэй уулын 1 чиглэлийг тохижуулахаар шийдвэрлэв. Тус чиглэлийн дагуу 07 дугаар сарын 25-ны өдөр хэмжилт хийж, хэмжилтийн дагуу явган аяллын зам дагуух хийгдэх объект, тохижилтын ажлын зургийг зургийг Оранж дизайн ХХК-ны дизайнер хийж гүйцэтгэв. Замын тохижилтын зургаар нийт 2 цэгт сүүдрэвч, сандал, анхааруулах самбар, зүг заасан тэмдэг бүхий амрах цэг, 6 цэгт түр амрах сандал, мэдээллийн самбарууд байрлуулж 12 сарын 03-ны өдөр ЧД-ийн ЗДТГ-т хүлээлгэн өгөв.

➤ Цайны замын хөшөөг байгуулав.

Монгол улс, ОХУ, БНХАУ-ын хамтарсан цайны зам олон улсын төслийн хүрээнд ӨМӨЗО-ны Аялал жуулчлалын газартай хамтран БЗД-ийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэр, Дулмаалин хийдийн хашаан дотор буюу Их Хүрээний хоёр өртөөний нэг болох зүүн хэсгийн “Цайны зам”-ын худалдааны Монголд хэрэглэх цайг буулгах, бусад аймаг хошуунд хуваарилах гол зангилаа газар болж байсан, Монголоор дайрч Европ руу тээвэрлэдэг цайны 10 орчим хувь нь энэ өртөөгөөр дамжин явж байсан түүхтэй энэ газарт 1м 85см-ийн өндөртэй, 1м 50см-ийн өргөнтэй, саарал өнгийн боржин чулуун дээр түүхийг хараар товойлгон зурж, үсгийг сийлж бичиж бүтээсэн “Цайны замын хөшөө”-г, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын Аялал жуулчлалын газрын хөрөнгө оруулалт /40.000 юаны/-аар барьж байгуулав. Хөшөөг 2017 оны 7 дугаар сарын 22-ны өдөр нээв.

Хөшөөний урд тал

Ар тал



➤ “Улаанбаатар брэнд лого” шалгаруулах уралдаан зарлав. Нийслэлийн Засаг даргын 2017 оны 07 сарын 03-ны өдрийн “Уралдаан зарлах тухай” А/497 захирамжийн дагуу Улаанбаатар хотын брэндийг бий болгох зорилготой “Улаанбаатар брэнд лого” шалгаруулах уралдааныг 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс 2017 оны 07 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж ажилласан бөгөөд уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийн тоо, чанар хангалтгүй байсан учир 2017 оны 9 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл сунган 9 оролцогчийн 13 бүтээлийг хүлээн шалгаруулав. Бүтээлийг шалгаруулахдаа Улаанбаатар хотын дүр төрхийг илэрхийлсэн бичвэр үсэгтэй, дүрс зурмалтай, зургийн хэмжээ /Dimension/ хамгийн багадаа 600px X 600px буюу 6 см x 6 см, зургийн нягтаршил /Image Resolution/ 600 pixels x 600 pixels хэмжээнээс дээш үзүүлэлттэй, бүтээлийн эх файлыг .ai, .psd Adobe Photoshop, Adobe Illustrator програм дээр бэлтгэсэн, олон төрлөөр ашиглаж болох өнгөний сонголт брэндбүүк танилцуулгатай ирүүлсэн иргэн Б.Яруусайхан, Т.Эрдэнэтуяа, Г.Баттогтох нарын бүтээлийг шалгаруулж, зохиогчийн эрхийн бүтээлийг ашиглах гэрээ байгуулан хүлээн авлаа. Бүтээлийг цаашид Улаанбаатар хотыг сурталчлан брэндинг хийх зорилгоор төлөвлөж байна.

➤ “Улаанбаатар аялал жуулчлалын үзэсгэлэн” зохион байгуулав. Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/322 дугаар захирамжаар дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, Монгол аялагчдад эх орны байгалийн үзэсгэлэнт газрууд, түүх соёлын дурсгалт газруудын талаар нэгдсэн мэдээлэл олгох, зөв зохистой аялах, ямар маршрутаар хаашаа, яаж аялах талаар зөвлөмж олгох зорилготой үндэсний аялал жуулчлалын “Улаанбаатар аялал жуулчлалын үзэсгэлэн”-г 19.633.000 төгрөгийн төсөвтэйгээр 3 дахь жилдээ Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Улаанбаатар аялал жуулчлалын холбоотой хамтран 2017 оны 6 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулав. Үзэсгэлэнд ОХУ, БНСУ, АНЭУ, БНЭУ-ын элчин сайдын яам, Баян-Өлгий, Баянхонгор, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Хэнтий аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газрууд, жуулчны бааз, рашаан сувиллын газрууд болон Хил хамгаалах ерөнхий газар, Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ, “Төрийн банк”, “Юнител” компани, Монголын Уулчдын үндэсний холбоо, Монголын Рафтингийн холбоо, Аялал жуулчлалын Боловсрол хөгжлийн нийгэмлэг зэрэг мэргэжлийн холбоодууд, тур оператор компаниуд, аялал жуулчлалын төсөл хөтөлбөрүүд зэрэг 80 гаруй байгууллага оролцож дотооддоо аялах аяллын маршрут, зөвлөгөө мэдээлэл, гадаад улс орон руу аялах амарч зугаалахтай холбогдсон мэдээ мэдээллийг өгч, аяллын холбогдолтой бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ иргэдэд танилцууллаа. Мөн үзэсгэлэнгийн үеэр иргэд аялагчдад зориулан МҮИС-ийн багш, судлаач, доктор профессор О.Сүхбаатар Монгол улсын хүрхрээг үзэж судлах аялал, Монголын Уулчдын үндэсний холбооны дэд ерөнхийлөгч С.Алдархишиг Дугуйн аялал, уулын спорт гайхамшгийн талаар, Монголиан гайд тур компанийн захирал Ч.Буянбадрах Гадаадад аялахад хэрхэн бэлтгэх талаар, гэрэл зурагчин Л.Жаргал Аяллын үеэр шувуу, амьтны зургийг хэрхэн авах вэ?, Монголын Цайны замын холбооны дэд тэргүүн Ш.Эгшиг Монголын нууц товчоо сэдэвт аяллын талаар илтгэлүүд тавьлаа. Энэ жилийн үзэсгэлэнгийн шилдгийн шилдэг оролцогчоор “Төрийн банк”, өвөрмөц тохижилттой оролцогчоор ОХУ-ын Шинжлэх ухаан соёлын төв “РЦНК” шалгарлаа.

Үзэсгэлэнг 8000 гаруй иргэн үзэж сонирхлоо. Энэ нь өмнөх онтой харьцуулахад оролцогч байгууллага 50%-иар нэмэгдэж, үзэж сонирхсон иргэдийн тоо 33%-иар нэмэгдэв.

➤ "Аялал жуулчлал ба ажил эрхлэлт" хөдөлмөрийн яармаг зохион байгуулав. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны А/36 дугаар тушаалын дагуу 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр нийслэлийн Улаанбаатар чуулгын байранд Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, Залуучуудын хөгжлийн газартай хамтран "Аялал жуулчлал ба ажил эрхлэлт" хөдөлмөрийн яармаг зохион байгуулав. Хөдөлмөрийн яармагт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 40 байгууллага оролцож аялал жуулчлалын чиглэлээр 500 гаруй нээлттэй ажлын байр зарлаж, 6 дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс болон Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар нийт 2000 орчим ажлын байрны санал ирүүлсэн. Хөдөлмөрийн яармагийн үеэр 1100 хүн анкет бөглөн, ажлын ярилцлага өгснөөс 194 хүн түр болон байнгын ажлын байртай болсон байна.

Үзүүлэлтийг графикаар үзүүлбэл:



➤ "Улаанбаатар" үсгэн хэлбэрт биет бэлгэ тэмдгийг байршуулав. Нийслэлийн Засаг даргын А/770 тоот захирамж, нийслэлийн Аялал жуулчлалын газрын А/81 тоот тушаалын дагуу "Улаанбаатар" үсгэн хэлбэрт биет бэлгэ тэмдгийг Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Улсын драмын эрдмийн театрын дэргэдэх талбайд байршуулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.5 дахь заалтыг үндэслэн "Б.Ц.Х.Ц" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгэв. "Улаанбаатар" үсгэн хэлбэрт биет бэлгэ тэмдгийн суурь нь 20 см өндөр, нийт 11 үсэг байх бөгөөд U, L, B, T үсгийн өндөр 170 см, бусад үсэг 108 см байх, үсгийн нийт урт 1025 см, зузаан 50 см, суурь болон үсгүүд лед гэрэлтүүлэгтэй. Цаашид арчлалт, хамгаалалтын ажлыг Сүхбаатар дүүргийн хот тохижилтын газарт хариуцуулан хүлээлгэн өгөв.

4. Аялал жуулчлалыг зохистой хөгжүүлэх чиглэлээр бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах чиглэлээр:

"Улаанбаатар хотын аялал жуулчлалыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийн төслийг холбогдох байгууллагуудаас санал авч, иргэд аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөллөөр хэлэлцүүлэн саналыг тусган, 2017 оны 06 сарын 15-ны өдөр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, НИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр, өргөн барив.

5. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр их дээд сургууль, коллеж, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллах, УБ хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрийн төсөл

боловсруулах, үйл ажиллагаанд мэргэжлийн холбоодын зөвлөмж, санал, дүгнэлтийг тусгах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:

➤ Стандартын төсөлд санал авч хэлэлцүүлэг зохион байгуулав. Зочлох үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэх зорилгоор Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ -Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS 4588:2008, Дэн буудал. Ерөнхий шаардлага MNS 5738:2007 стандартуудыг шинэчлэн, Гэст хаусын стандартыг шинээр боловсруулан Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба, Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Байгаль орчны газар, Улаанбаатар хотын Цагдаагийн газар зэрэг байгууллагуудаас 2017 оны 2 сарын 06-ны өдрийн 01/68 дугаар албан тоотой стандартыг төслийг хүргүүлж ирсэн саналыг тусгасан. Мөн 2017 оны 3 сарын 15-ны өдөр аялал жуулчлал зочлох үйлчилгээний байгууллагуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж гарсан саналыг нэгтгэн хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ын 128 удирдлага, менежерүүд, Монголын Аялал жуулчлалын холбоо, Монголын Зочид буудлуудын холбоо, Аялал жуулчлалын мэргэжлийн ур чадварын сургалтын төв ТББ-уудын төлөөлөл, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургуулийн багш эрдэмтэд, дүүргүүдийн аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн зэрэг нийт 200 гаруй хүн оролцож саналаа өглөө.

➤ Хөтөлбөрийн төсөлд санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулав. Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/30 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсэг Улаанбаатар хотод Аялал жуулчлалыг 2017-2020 онд хөгжүүлэх хөтөлбөрийн төсөл боловсруулан Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Соёл урлагын газар, Биеийн тамир, спортын хороо, Улаанбаатар хотын Цагдаагийн газар, Хот төлөвлөлт, Ерөнхий төлөвлөгөөний газар зэрэг байгууллагуудаас санал авч нэгтгэв. Хөтөлбөрийн төслөөр 2017 оны 3 дугаар сарын 24-ний өдөр Хангарди ордны Их танхимд хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн 60 гаруй хүн хамрагдав.


6. Улаанбаатар хотыг гадаад улсад сурталчлах ажлыг хариуцан зохион байгуулах, энэ чиглэлээр маркетингийн стратеги, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Гадаад сурталчилгааны маркетингийн төлөвлөгөө боловсруулав. Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах 11 заалттай маркетингийн төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилт 81 хувьтай байна.

7. Гадаад, дотоодын жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох төрийн болон ТББ-тай хамтран ажиллах ажлын хүрээнд:

➤ Санамж бичиг байгуулав. Гадаад, дотоодын иргэд, жуулчдыг гэмт халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх, цагдаагийн албан хаагчдын гадаад хэлний мэдлэг, ур чадварыг сайжруулах, олон нийтийн арга хэмжээний үед болон Горхи, Тэрэлжийн бүс нутаг, Туул голын сав газраар морин, завьт, машинт эргүүл ажиллуулах, жуулчны бааз, амралтын газар, шөнийн клуб, ресторан, паб, зочид буудал зэрэг газруудын харуул, хамгаалалтыг өндөржүүлэх чиглэлээр Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Цагдаагийн газартай 2017-2020 онд хамтран ажиллах Санамж бичгийг 2017 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр байгуулан, төлөвлөгөө гарган ажиллаж байна. 2013-2016 онд мөн Санамж бичиг байгуулан ажилласнаар гадаадын иргэд гэмт хэрэгт өртөж хохирсон 2014 онд -8%, 2015 онд -13%, 2016 онд -10% тус тус буурсан. 2017 оны эхний хагас жилийн байдлаар 51 хүн өртөж энэ өмнөх оны мөн харьцуулахад 89 хүн буюу -42% буурсан. Үр дүнгээ өгсөн ажил тул үргэлжлүүлэн хэрэгжүүлэн ажиллав.

Сүүлийн 4 жилийн тоон үзүүлэлтийг графикаар үзүүлбэл:



Тайлбар: Судалгаагаар Монгол улсад түр болон байнгын оршин суугч, суралцагч, хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэдийн тоо ороогүй болно.

➤ “Жуулчинд ээлтэй оюутан цагдаа” хөтөлбөр хэрэгжүүлэв. НАЖГ, НЦГ, МОХ-той хамтран “Жуулчинд ээлтэй оюутан цагдаа-2017” арга хэмжээг 6,7,8-р сард их, дээд сургуулийн 30 оюутныг хамруулан 4 дэх жилдээ зохион байгуулж, 2017 оны 08 дугаар сарын 16-ны өдөр ажлаа дүгнэлээ. Оюутан цагдаа нар нь гадаадын иргэд, жуулчдад хотын үзвэр, үйлчилгээ, гудамж, талбайд аялах, зорчих үед нь мэдээллээр хангаж, гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлж, жуулчид ихээр зорчдог 15 чиглэлд 300 хүн/цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, нийслэл хотод зохион байгуулагдсан Ази номхон далайн бүсийн чуулга уулзалт, Шөнийн гэрэлт гудамж, Үндэсний их баяр наадам, Даншиг наадам-Хүрээ цам арга хэмжээний үеэр ажиллав. НАЖГ, НЦГ, НОБГ-аас гаргасан түүх, соёл, үндэсний их баяр наадам, хэв журам, онцгой байдал, эрүүл ахуйн чиглэлийн товч танилцуулга, зөвлөмж бүхий 25 төрлийн 8600 гаруй ширхэг эвхмэл танилцуулга, УБ хотын газрын зураг зэргийг түгээж, гадаадын 8752, дотоодын 5658 иргэнд эрх зүй, аялал жуулчлалын мэдээ, мэдээллээр хангав. Оюутан цагдаа ажилласан хугацаанд гэмт халдлагад өртөж хохирсон тохиолдол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33,33 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Арга хэмжээнд сайн оролцсон оюутнуудыг НАЖГ, НЦГ, МОХ-ноос шагнав. Хөтөлбөрийг 2014 оноос анх хэрэгжүүлж эхэлсэн. Хөтөлбөрт 2014 оноос эхэлж 100, 2015 онд 85, 2016 онд 110, 2017 онд 30 оюутан хамрагдаж, энэ хугацаанд гэмт хэрэгт өртсөн зөрчлийн тоо 2014 онд -17% /35/, 2015 онд -20%/28/, 2016 онд -18%/23/, 2017 онд 33%/16/-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Үр дүнгээ өгсөн ажил тул үргэлжлүүлэн хэрэгжүүлэв.

Сүүлийн 4 жилийн тоон үзүүлэлтийг графикаар үзүүлбэл:



➤ Зөвлөмж боловсруулан гаргав. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт морь, тэмээ унуулах ердийн хөсгөөр аялал зохион байгуулж буй иргэд, орон нутгийн хөтчүүдийг нэгдсэн зохион байгуулалтад оруулах, үйлчилгээний зөвлөмж боловсруулах ажлын хүрээнд Налайх дүүргийн 6 дугаар хороо, ХУД-ийн Өлзийн хорооны иргэд, жуулчны бааз нийт 20 гаруй ААНБ, иргэдээс 2016 онд

авсан саналд үндэслэн 2017 оны А/39 дүгээр тушаалаар Ердийн хөсгөөр аялах, аялуулах зөвлөмж батлав. Тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор төлөвлөгөө боловсруулж баталсан. Төлөвлөгөөнд ердийн хөсгөөр үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн судалгаа хийх, зөвлөмжийг сурталчлах, сургалт зохион байгуулах, цахимаар болон гарын авлага материал болгон тараах, хүргэх ажлуудыг хийж байна.

➤ Автобусны зогсоолд англи хэл дээр маршрутын мэдээлэл байршуулав. Жуулчид ихээр зорчдог Энхтайваны өргөн чөлөө болон Зайсан, МУБИС, Ионсей эмнэлэг, Хөдөлмөрийн яам, Бөхийн өргөө, Улсын их дэлгүүр, Энхтайван найрамдлын ордон, Санктпетербург, Төв номын сан, Баянгол зочид буудал, 120 мянгат, Төв цэнгэлдэх хүрээлэн, Оргил рашаан сувилал, Зайсан, Мөнгөн Завьяа зэрэг нийт 17 автобусны зогсоолд англи хэл дээр маршрутын мэдээллийг байршуулах ажлыг Нийслэлийн Тээврийн газартай хамтран хийв. Мөн “Улаанбаатар Смарт карт” ХХК-иас “UB smart bus” гар утасны аппликейшныг жуулчдын үйлчилгээнд ашиглуулах боломжтой болгосон.

8. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжилтийг төрийн болон ТББ-тай хамтран зохион байгуулах, мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод сургалтад хамруулж, мэргэшлийг дээшлүүлэх ажлын хүрээнд:

- НЗДТГ, БНСУ-ын Пусан хотын захиргаанаас нутгийн засаг, захиргааны байгууллагуудыг ажилтнуудын “K2H” солилцооны 6 сарын хөтөлбөрт 1 ажилтанг хамруулж, НҮИГ-аас зохион байгуулсан Мега төсөл ба төслийн санхүүжилт, төслийн гэрээ, хэлэлцээрийн үндсэн бүтэц, гэрээ байгуулахад анхаарах асуудал сэдэвт сертификаттай сургалтад 1 ажилтан, НЗХГ-аас зохион байгуулсан 45 хоногийн Компьютерийн үндсэн хэрэглээ сэдэвт сертификаттай сургалтад 1 ажилтан, НЗДТГ-аас зохион байгуулсан Бодлогын баримт бичиг боловсруулах сургалтад 3 ажилтан, НЗДТГ, Нийслэлийн Хүүхэд гэр бүл, хөгжлийн газраас зохион байгуулсан шинээр батлагдсан хуулийг хэрэгжүүлэх, сурталчлах зорилготой Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг танилцуулах сургалтад 1 ажилтан, НАГ-аас зохион байгуулсан Албан хэрэг хөтлөлтийн сургалтад архив, бичиг хэргийн эрхлэгч 3 удаа, НЗХГ, НАЖГ-ын хамтран зохион байгуулсан Гадаадын жуулчны хөтөч бэлтгэх сертификаттай сургалтад 4 албан хаагч тус тус хамрагдав. Мөн Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан Албан хэрэг хөтлөлтийн сургалтад нийт 18 албан хаагч, Монгол улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврын хүрээнд 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Төрийн албаны зөвлөлийн ахлах референт Зоригтбаатар Төрийн албан хаагчийн ёс зүй, Үр дүнгийн гэрээ байгуулах талаар сургалтад нийт 21 албан хаагч, БОАЖЯ-тай хамтран зохион байгуулсан Дэлхийн Аялал жуулчлалын байгууллагын зөвлөх, эксперт Стэфэн Ноакийн “Тогтвортой аялал жуулчлал, тогтвортой хөгжлийн зорилт 2030-д аялал жуулчлалын салбарын оруулах хувь нэмэр” сертификаттай сургалтад нийт 17 албан хаагч хамрагдаж, “Виз болон гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах тухай журам” сэдэвт сургалтыг ЗДТГ-ын Гадаад харилцааны хэлтэстэй хамтран зохион байгуулж сургалтад бүх ажилтнуудыг хамруулав. 3 ажилтан мэргэжлээ дээшлүүлэн магистр болон бакалаврын зэрэг олгох сургалтад суралцаж байна.

9. Улаанбаатар хоттой хамтын ажиллагаатай хотуудтай аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах, нийслэл хотын нутаг дэвсгэрт байгаа аялал жуулчлалын нөөцийг сурталчлах, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, шинээр бий болгох ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:

А/. Улаанбаатар хотыг бие даасан зорих газар болгон хөгжүүлэх зорилгоор голлох зах зээлийн орнуудад чиглэсэн маркетингийн цогц арга хэмжээг хэрэгжүүлж Улаанбаатар хотыг сурталчлав. Үүнд:

1. “UB 240” унадаг дугуйн аялал зохион байгуулав. Улаанбаатар хотыг сурталчлах зорилгоор МБ олон улсын унадаг дугуйн холбоотой хамтран 24 цагийн хугацаанд 240 км замыг тойрох “UB 240” унадаг дугуйн аяллыг 06

дугаар сарын 2,3-ны өдөр зохион байгуулав. Тус аялалд гадаад дотоодын 34 багийн 203 аялагч дугуйчид оролцов.

2. БНХАУ-ын сошиал сувгаар Улаанбаатар хотыг сурталчлав.

БНХАУ-ын нэрт аялагч блогчин Сун Жиэн болон түүний баг хамт олон Улаанбаатар хоттой танилцах, Улаанбаатар хотыг БНХАУ-д улсад сошиал сувгаар сурталчлуулах зорилгоор 05 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд манай хотод аялал хийж аялал жуулчлалын салбарынхантай уулзалт зохион байгуулав. Уулзалтад БНХАУ-ын зах зээлд үйл ажиллагаагаа явуулдаг аялал жуулчлалын 11 компанийн төлөөлөл оролцов.

3. БНХАУ-ын Бээжин хотноо 2017 оны 12 сарын 20-ны өдөр Хятад улсын хамгийн том мэдээллийн сайт www.china.com.cn-тай хамтран ажиллах Санамж бичгийг байгуулав.

4. Хотын сурталчилгааг хийв.

“МИАТ” ТӨХК БНСУ-ын Бусан хот руу шинэ чиглэл нээж байгаатай холбогдуулан Кимхе олон улсын нисэх буудалд зохион байгуулагдсан анхны нислэгийн нээлтийн үйл ажиллагаа болон хүлээн авалтад Бусан хотын Аялал жуулчлалын газарт мэргэжилтэн солилцоогоор ажиллаж байгаа тус газрын мэргэжилтэн Б.Амарзаяаг оролцуулж мэдээллээр хангаж ажиллав. Тус арга хэмжээний үеэр Улаанбаатар хотыг сурталчлах зорилгоор Ulaanbaatar Your GateWay сэтгүүлээс 100 ширхэг, Солонгос хэл дээрх Улаанбаатар хотын танилцуулга 200 ширхгийг “МИАТ” ТӨХК-иар дамжуулан Бусан хот руу тээвэрлүүлж сурталчилгаа хийв.

Б/. Аялал жуулчлалын олон улсын томоохон үзэсгэлэнд аялал жуулчлалын компаниудтай хамтран нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцож Монгол улсын сурталчилгааг хийв. Үүнд:


1. Ай-Ти-Би Берлин олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцов. 2017 оны 3 сарын 04-10-ны өдрүүдэд ХБНГУ-ын Берлин хотноо болсон Ай-Ти-Би Берлин олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/97 дугаар захирамжийн дагуу тус газрын дарга Д.Батсүх, мэргэжилтэн Я.Сарангэрэл нар оролцов. Үзэсгэлэнд БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, сайдын зөвлөх Д.Гансүх, Герман Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Ц.Болор нар болон Монголын Аялал жуулчлалын холбоо, МИАТ ХК, аялал жуулчлалын 9 компани нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцож нийт 121 м.кв талбайд тохижилт хийсний 1/3 хэсэгт нийслэлийн Аялал жуулчлалын газар Улаанбаатар хотыг сурталчлав. Үзэсгэлэнгийн үеэр ХБНГУ-ын Берлин хотын дарга ноён Михайл Мюллер, Эдийн засаг, эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Ирис Глайке, “Мессэ Берлин” компаний захирал Кристиан Гёке, Герман улсын Аялал жуулчлалын холбооны Ерөнхийлөгч Михайл Френцэл болон Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын ерөнхий нарийн бичгийн дарга ноён Талиб Рифай нар Монгол улсыг онцолж үзэсгэлэнгийн талбайн нээлтэд оролцсон нь чухал ач холбогдолтой байлаа. Үзэсгэлэнд оролцогч орны тоо 2016 онд 5,5%-иар, 2017 онд 2%-иар өссөн, 190 орны 10.000 гаруй байгууллага оролцдог олон улсын хамгийн том аялал жуулчлалын үзэсгэлэн. Үзэсгэлэнд өнгөрсөн жил МИАТ ХК, аялал жуулчлалын 6 компани нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцсон бол энэ жил МАЖХ, аялал жуулчлалын 3 компани нэмэгдэж оролцов. Үзэсгэлэнд тогтмол оролцож, сурталчилгаа хийснээр 2017 оны эхний 09 сарын байдлаар улсын хилээр нэвтэрсэн нийт зорчигч 440.227 үүнээс 384.949 жуулчин ирсэн ба энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.56%-иар, салбарын орлого 336.401.692 доллар буюу 23.2%-иар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Голлох зах зээлийн орноор авч үзэхэд Герман улс эхний 8-д жагсдаг байна. Үүнээс европ жуулчдын тоо 142.405 буюу 20.295-аар нэмэгдэж 14.25%-иар, Герман жуулчдын тоо 9.731 буюу 1735-аар нэмэгдэж 17.8%-иар тус тус өссөн байна. 80 гаруй сая хүн амтай Герман улсын хувьд манай улсад зөвхөн 8% нь жуулчилдаг байна. Шууд нислэгтэй, визний хөнгөлөлттэй тул Герман болон Европ улсаас ирэх жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх боломжтой. Энэ жилийн үзэсгэлэнд 42.340.600 төг, 2.980 ам.доллар, 12.370 евро зарцуулж, талбайн тохижилт хийж оролцсон бол өмнөх жилд 55.174.534 төг төсөвлөснөөс 1 хүн оролцож, 24.825.466 төг хэмнэсэн байна.

Сүүлийн 4 жилийн тоон үзүүлэлтийг графикаар үзүүлбэл:



2. “Байкалтур-2017” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцов. Оросын Холбооны улсын “Байкалтур-2017” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 20 дахь жилдээ Эрхүү мужийн “Сибэкспоцентр” төвд 2017 оны 03 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд “Их цайны зам” сэдвийн хүрээнд зохион байгуулагдав. Монгол Улсын аялал жуулчлалыг олон улсад сурталчлан таниулах, ах дүү хотуудын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, Улаанбаатар хотыг чиглэсэн жуулчдын урсгал болон дамжин өнгөрөх тоог нэмэгдүүлэх зорилготой энэхүү үзэсгэлэнд Монгол улсаас ОХУ-ын Эрхүү мужид суугаа Ерөнхий консул Л.Амарсанаа оролцож нээлтийн үйл ажиллагаанд үг хэлсэн. Тус үзэсгэлэнд Улаанбаатар хотыг төлөөлж Нийгмийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч, нийслэлийн засаг даргын орлогч Ш.Анхмаа, тус газрын дарга Д.Батсүх болон бусад ажилтнууд оролцож, Улаанбаатарын Аялал жуулчлалын холбоо, UBS телевиз, Зочид буудал, тогооч нарын холбооны төлөөллүүд, аялал жуулчлалын 8 компани хамтран Монгол улсаа сурталчиллаа. Үзэсгэлэнд 220 байгууллага оролцож, 10 000 гаруй хүн үзэж сонирхов. Улаанбаатар хот үзэсгэлэнд идэвхтэй ажиллаж, үндэсний онцлогийг харуулсан стенд, эвент арга хэмжээ зохион байгуулж, зочдын сонирхлыг татсан тул зохион байгуулагчийн шагнал “Золотая звезда” /Алтан Од/ цом, өргөмжлөлийг хүртлээ. Үзэсгэлэнд оролцсоноор 2017 оны эхний 09 сарын байдлаар ОХУ-аас ирэх жуулчдын тоо 80.157 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.406-аар нэмэгдэж, 20.5%-иар өссөн үзүүлэлттэй байна. 146 сая хүн амтай ОХУ-аас манай улсад зөвхөн 2 орчим хувь нь жуулчилдаг байна. Харин өнгөрсөн онд манай улсын 522.026 иргэн ОХУ-д жуулчилсан байна. Бусад орны аялал жуулчлалын зах зээлийн судалгаанаас үзэхэд голлох жуулчид нь хил залгаа орноос нь ирдэг байна. ОХУ 2016 онд 24 сая жуулчин хүлээн авсны эхний 10-т Украин, Казакстан, Финлянд, БНХАУ, Польш, Азербайджан, Узбекистан, Армен, Герман, Монгол улсууд тэргүүлж нийт жуулчдынх нь 77%-ийг бүрдүүлсэн байна. Улаанбаатар хот “Байкалтур” үзэсгэлэнд өмнө нь 2012 онд оролцож байсан ба 2016 онд Москва хотод болсон МИТТ олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Москва хот дахь Улаанбаатар хотын төлөөлөгч М.Мөнхцэцэг төлөөлөн сурталчилгаа хийж оролцжээ. Цаашид аялал жуулчлалын үзэсгэлэнд тогтмол оролцох, 1960-1990 онд Монгол улсад ажиллаж, амьдарч, сурч, цэргийн алба хааж байсан иргэдэд зориулсан “Ностальгический тур” буюу “Дурсамж” болон тусгай сонирхлын аяллын хэрэгцээ маш их байгаа. Шууд нислэгтэй, галт тэрэг, авто замаар 2 улсын иргэд харилцан визгүй зорчдог хөнгөлөлттэй тул ОХУ улсаас болон дамжин ирэх жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх боломжтой байна.

Сүүлийн 4 жилийн тоон үзүүлэлтийг графикаар үзүүлбэл:



3. ЖАТА олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцов. Япон улсын Токио хотод жил бүр зохион байгуулагддаг ЖАТА олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 2017 оны 9-р сарын 21-24-ний өдрүүдэд 40 дэх жилдээ зохион байгуулагдлаа. Үзэсгэлэнд Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/658 дугаар захирамжийн дагуу тус газрын дарга Д.Батсүх, хэлтсийн дарга Д.Жавхлан нар оролцов. Үзэсгэлэнд Нийслэлийн Аялал жуулчлалын газар ерөнхий зохион байгуулагчаар ажиллаж МИАТ ХК, Бирга Тур ХХК, Цэцэг зочид буудал, Говь Тур ХХК, Айрис Турс ХХК, Жигүүр ХХК, Жуулчин ХХК, Летс Трэвел ХХК, Номадик Туризм аялал жуулчлалын агентлагууд, Ялгуун брэндтэй хамтран эх орноо сурталчлаж, нийслэлийн Улаанбаатар чуулгын уран бүтээлчдийн үндэсний урлагийн тоглолтоос ирсэн зочдод үзүүлэв. Үзэсгэлэнгийн нээлтэд УИХ-ын гишүүн М.Оюунчимэг, БОАЖ-ын Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга С.Бат-Эрдэнэ, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх, Япон Улсын Элчин Сайдын яамны Түр хамаарагч Д.Батжаргал нар оролцлоо. Үзэсгэлэнгийн үеэр Япон улсын Орон нутаг, дэд бүтэц, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын газрын дарга Казүо Чүжо болон орлогч комиссар Ясуто Каварабаяши нартай БОАЖЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, тус газрын дарга Д.Батсүх болон албаны бусад төлөөллүүд уулзаж хоёр орны аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах санамж бичиг үйлдэх, Улаанбаатар хотыг сурталчлах талаар санал солилцов. Тус газраас Улаанбаатар хотын Япон хэл дээрх сурталчилгааны сэтгүүл 900 ширхгийг үзэсгэлэнгийн үеэр түгээж, Монгол улсаас Япон улсад суугаа Элчин Сайдын Яаманд 100 ширхэг сэтгүүл хүргүүлэв. Азийн аялал жуулчлалын хамгийн том үзэсгэлэнд оролцсон нь олон улсын аялал жуулчлалын зах зээлд Монгол улсын эзлэх байр суурийг баталгаажуулах, сурталчлан таниулах, өрсөлдөх чадварыг сайжруулах, улмаар жуулчдын тоог нэмэгдүүлэхэд ач холбогдолтой арга хэмжээ боллоо. Дэлхийн 150 орон, 1.310 байгууллага оролцсон энэхүү үзэсгэлэнд Улаанбаатар хот өмнө нь 2015 онд оролцсон. Энэ удаагийн үзэсгэлэнд оролцогч орны тоо 6.3%-иар, оролцогч байгууллагын тоо өмнөх жилүүдээс 12.8%-иар өссөн, 191.500 гаруй хүн үзсэн. Үзэсгэлэнд оролцсоноор 2017 оны эхний 09 сарын байдлаар ази, номхон далайн орнуудын жуулчдын тоо 221.322 буюу 37.500-аар нэмэгдэж, 16.94%-иар, Япон жуулчдын тоо 19.623 буюу 2.044-өөр нэмэгдэж, 10.4%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. 127 сая гаруй хүн амтай Япон улсаас манай улсад зөвхөн 7% нь ирдэг байна. Шууд нислэгтэй, визний хөнгөлөлттэй тул цаашид Япон улсаас ирэх жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх боломжтой.


Сүүлийн 4 жилийн тоон үзүүлэлтийг графикаар үзүүлбэл:




Сүүлийн жилүүдэд аялал жуулчлалын олон улсын томоохон үзэсгэлэнд төр, хувийн хэвшлийнхэн хамтарч Монгол улсыг нэгдсэн зохион байгуулалттайгаар гадаадад сурталчилж ажилласнаар 2017 оны эхний 11 сарын байдлаар манай улсад ирсэн нийт зорчигчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 62.097-оор буюу 12.26 хувиар өссөн ба жуулчдын тоо 69.238-аар буюу 15.32 хувиар өссөн байна.

2017 оны эхний 11 сарын байдлаар салбарын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 382.760.396 доллар буюу 21.3 хувиар өссөн байна.

2017 оны эхний 11 сарын байдлаар статистикийг графикаар үзүүлбэл:



Салбарын оролого сүүлийн 4 жилээр үзүүлбэл:



10. Аялал жуулчлалын байгууллагуудын дунд аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр төрөл бүрийн сургалт зохион байгуулах ажлын хүрээнд:

- Монголын Хөтөч тайлбарлагчдын холбоотой хамтран 2017 оны 04 сарын 05-наас 05 сарын 05 хүртэл хугацаанд “Хөтөч тайлбарлагчдын чадваржуулах” сургалтыг зохион байгуулав. Сургалтад 43 хүн хамрагдаж, шалгалтад тэнцсэн 16 хүнд Хөтөч мэргэжлийн сертификат олгов.
- Гадаад хэлний зохих мэдлэгтэй оюутан, хөдөлмөр эрхлээгүй залуучуудын ур чадварыг сайжруулах, аялал жуулчлалын салбарт хөдөлмөр эрхлэх бололцоотой боловсон хүчнийг нэмэгдүүлэх, тэдгээрийн мэргэшил, мэдлэгийг сайжруулах, гадаадын жуулчдад үйлчлэх аяллын хөтчийг мэргэжлийн арга зүйгээр хангах зорилгоор Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газартай хамтран “Гадаадын жуулчны хөтөч бэлтгэх” сургалтыг 2017 оны 05 дугаар сарын 26-наас 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэл 5 хоногийн хугацаанд зохион байгуулав. Нийт 600 гаруй хүн бүртгүүлснээс 326 хүн сургалтад хамрагдаж, 282 хүн амжилттай суралцаж, батламж авлаа.
- Нийслэлийн харьяа газар, агентлагийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтнүүд, тус газрын ажилтнуудад зориулсан “Виз болон гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах тухай журам” сэдэвт сургалтыг 2017 оны 3 сарын 14-ний өдөр Хангазрьд ордонд ЗДТГ-ын Гадаад харилцааны хэлтэстэй хамтран зохион байгуулав. Сургалтад “Монгол Улсын иргэн гадаад улс оронд зорчих, “Гадаадын иргэн, жуулчид Монгол Улсад зорчих” сэдвийн хүрээнд ГХЯ-ны Консулын газрын орлогч захирал Л.Мөнхтүшиг, “Гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам” сэдвээр ГХЯ-ны 2 дугаар нарийн бичгийн дарга Д.Батбилэг, Консулын газрын мэргэжилтэн Ц.Майцэцэг нар мэдээлэл өгөв. Сургалтад 60 гаруй хүн хамрагдав.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран Дэлхийн Аялал жуулчлалын байгууллагын зөвлөх ноён Стефен Ноаксийг Монгол улсад урьж “Аялал жуулчлал ба тогтвортой хөгжлийн зорилтууд” сэдвийн доор 3 өдрийн эрчимжүүлсэн сургалтыг 2017 оны 12 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд зохион байгуулав. Сургалтад БОАЖЯ, НАЖГ, 21 аймаг, 9 дүүргийн аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн, аялал жуулчлалын төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийн 150 хүн хамрагдаж, 9.640.000 төгрөг зарцуулав.



Мэргэжлийн сургалтад зарцуулсан төсөв. Сүүлийн 4 жилээр харуулбал:

Он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Зарцуулсан төсөв сая/төг	3.222.878	11.063.360	40.000.000	9.916.000

11. Гадаад, дотоодын жуулчдыг хэрэгцээт мэдээллээр шуурхай хангаж, УБ хотын талаарх сурталчилгааны материалуудыг тогтмол шинэчлэх арга хэмжээ авч ажиллах талаар:

Сурталчилгааны материал хэвлүүлэв.

Жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, Улаанбаатар хотыг сурталчлах сурталчилгааны материалд зориулж тус газраас Улаанбаатар хотын газрын зураг 10.000 ширхэг, “Улаанбаатар жуулчны хөтөч” гарын авлага номыг англи хэл дээр 6.800 ширхгийг хэвлүүлж гадаад, дотоодод зохион байгуулагдсан үзэсгэлэн, арга хэмжээний үеэр ашиглав. Сурталчилгааны материалд 34.700.000 төгрөг зарцуулав.

12. Гадаад оронд зохион байгуулагдах аялал жуулчлалын хурал, зөвлөгөөн үзэсгэлэн, арга хэмжээнд энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа ААНБ-уудыг хамруулах талаар:

➤ 2017 оны 4 сарын 18-22-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотод зохион байгуулагдсан Эдийн засаг худалдаа, хөрөнгө оруулалтын бизнес форум, Монголын өдрүүд үзэсгэлэнгийн арга хэмжээнд тус газрын орлогч дарга Ц.Энхтүвшин оролцов.

2017 оны 5 сарын 25-28-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хянган аймгийн Улаан хотод хийх албан айлчлалын бүрэлдэхүүнд тус газрын орлогч дарга Ц.Энхтүвшин ажиллав.

➤ ОХУ-ын Буриад улсын Улаан-Үд хотноо 2017 оны 06 дугаар сарын 21-24-ний өдрүүдэд “Монгол улс, ОХУ, БНХАУ-ын Аялал жуулчлалын сайд нарын хоёрдугаар хуралдаан” зохион байгуулагдав. Уг хуралдаанд тус газрын орлогч дарга Ц.Энхтүвшин оролцов. Хуралдааныг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, ОХУ-ын Холбооны аялал жуулчлалын агентлагийн дарга Сафонов Олег Петрович, БНХАУ-ын Үндэсний аялал жуулчлалын газрын дарга Ли Цзиньцзао нар даргалан явууллаа. Мөн 06 дугаар сарын 22-ны өдөр ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад улсын Заиграев мужийн Ацагат тосгонд “Цайны зам” аялал жуулчлалыг дэмжих таван бүс нутгийн Орос-Хятад-Монголын Зохицуулах зөвлөлийн дөрөвдүгээр хурлыг зохион байгуулж протоколд гарын үсэг зурав. Тус хуралдаанд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, тус газрын орлогч дарга Ц.Энхтүвшин, ОХУ-ын Аялал Жуулчлалын Холбооны агентлагийн төлөөлөгч А.А.Конюшков, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Аялал жуулчлалын товчооны дарга Вэй Гуонан, ОХУ-ын Бүгд Найрамдах Бурят улсын Эдийн засгийн яамны Эдийн засгийн яамны орлогч сайд Т.Б.Будаев, ОХУ-ын Эрхүү мужийн Аялал жуулчлалын агентлагийн дарга Е.С.Славина, ОХУ-ын Өвөр Байгалийн хязгаарын Олон улсын хамтын ажиллагааны гадаад эдийн засгийн харилцааны яамны орлогч сайд В.И.Аникьев, “Улаан-Үд”, “Хиагтын район”, “Сэлэнгэ бүсийн” орон нутгийн засаг захиргааны төлөөлөгчид оролцов.

13. Жуулчдад зориулсан мэдээлэл сурталчилгааны төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар:

➤ Жуулчны мэдээллийн төвүүдийг тохижуулав.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дэргэдэх Жуулчны мэдээллийн төв болон Сөүлийн гудамжинд байрлах Улаанбаатар хотын Цагдаагийн газрын Иргэдэд үйлчлэх төвийн “Жуулчны мэдээллийн төв”, “Шударга худалдаа, жуулчны мэдээллийн цэг” /Tourist information and Fair trade center/-ийн үйл ажиллагааг сайжруулах, Шөнийн гэрэлт гудамж төслийг хэрэгжүүлж байгаатай холбогдуулан Сөүлийн гудамжинд Гэр мэдээллийн төвийг тохижуулах зорилгоор Нийслэлийн Засаг дарга 2017 оны А/380 дугаар захирамж гаргаж “Түмэн Цагаан Гэр” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, 2 ширхэг авдар, 1 ширээ, 8 сандал, 1 брошурын тавиурыг тус тус захиалан хийлгэж, Эм Пи Эм ХХК-иас 90x170 хэмжээтэй /газрын зураг/ 2 ширхэг, 120x230 хэмжээтэй /газрын зураг/ 1 ширхэг нийт 3 ширхэг Улаанбаатар хотын газрын зураг худалдан авч мэдээллийн төвүүдэд байршуулав. Улаанбаатар хотын түүхэн болон орчин үеийн 6 ширхэг гэрэлт зургийг Сөүлийн гудамжинд байрших Гэр мэдээллийн төвийн хананд байршуулж, UNIPRESS ХХК-иар мэдээллийн төвийн гаднах хаягыг Англи болон Монгол хэл дээр хийлгэж суурилуулсан. Жи-Мобайл ХХК-тай гэрээ байгуулж интернетийн холболт хийж мэдээллийн төвийг интернет сүлжээнд холбож, КоллПро ХХК-тай хамтран ажиллах гэрээ сунгаж, мэдээллийн төвийн суурин утас, дуудлага хадгалах үйлчилгээ, автомат хариулагч зэргийг ажиллуулж эхлээд байна. Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны байранд “Шударга худалдаа,

жуулчны мэдээллийн цэг"-ийг ажиллуулах түрээсийн гэрээг 2017 оны 06-р сарын 01 -нээс 12-р сарын 31 хүртэл хугацаатайгаар байгууллаа. 2017 онд зохиогдох соёл урлагийн тоглолтуудын хуваарь, эвент арга хэмжээний мэдээллийг сар бүр, үйлчилгээний байгууллагуудын мэдээллийг тухай бүрт нь шинэчлэв. 2017 онд Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдээр нийт 21260 гадаад, дотоодын иргэд, жуулчид үйлчлүүлэв.

14. Жуулчдын санал, гомдлыг хүлээн авч, тэдгээрийг хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах талаар:

2017 онд Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдээр нийт 21260 гадаад, дотоодын иргэд, жуулчид үйлчлүүлэв. Жуулчдаас ирүүлсэн санал гомдлыг тухай бүрд нь холбогдох байгууллагуудад мэдээлж, туслалцаа үзүүлж ажиллав.

15. Нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг бүртгэж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж хөтлөх талаар:

Нийслэлийн хэмжээнд болон орон нутгийн аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг бүртгэж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэн мэдээллийг тухай бүрт нь шинэчлэн ажиллав. Тус газрын мэдээллийн санд 403 тур оператор, зөвшөөрөлтэй 144 зочид буудал, 142 дэн буудал, 10 амралтын газар, 107 жуулчны бааз, 36 музей галлерей, 14 урлагын байгууллага, үзвэр үйлчилгээний газар, 4 номын дэлгүүр, 20 гаруй худалдааны төв, 128 түүх соёлын дурсгалын тайлбар мэдээлэл, ресторан, зоогийн газар, орон нутгийн аялал жуулчлалын байгууллагууд зэрэг 2000 гаруй байгууллагын мэдээллээр мэдээллийн сан үүсгэж, 10.000 гаруй мэдээ, мэдээллийг бэлтгэж мэдээлж ажилласан байна.

16. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагад эрхэлсэн асуудлын чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, холбогдох мэдээллийг шуурхай гаргаж өгөх талаар:

Эрхэлсэн ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Гадаад харилцааны яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүд, Захирагчийн ажлын алба, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагууд, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа их дээд сургуулиуд, төрийн бус байгууллагууд болон аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээ мэдээллийг цаг тухайд түргэн шуурхай өгч ажиллав.

17. Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах талаар:

Нийслэлийн Цагдаагийн газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, Гэрлэх Ёслолын ордон ОНӨААТҮГ, Бүргэдчдийн холбоо, Нийслэл Масс Медиа ХХК-тай хамтран ажиллах Санамж бичиг байгуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

18. Хууль тогтоожмид заасан бусад чиг үүргийн хүрээнд:

А. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

➤ Авилгын эсрэг хууль тогтоомж, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор tourism.ub.gov.mn цахим хуудас, шилэн данс цэсийн мэдээллийг цаг тухай бүр шинэчлэн ажиллаж байна.

➤ Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас тус байгууллагын 2016 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын талаар Нийслэлийн удирдлагын зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн дагуу 22 заалттай ажлын төлөвлөгөө боловсруулж 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдөр газрын даргаар батлуулж төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллав.

- Нийслэлийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврыг газрын хурлаар нийт албан хаагчдад тогтмол танилцуулж, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хүний нөөц, аялал жуулчлалын байгууллага хариуцсан мэргэжилтэн хяналт тавин ажиллав. Тус газартай холбоотой үүрэг даалгаварын биелэлтийг Ulaanbaatar.mn цахим хуудсанд байршуулж хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллав. Газрын хурлыг сард 1 удаа зохион байгуулж нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавар, байгууллагын төлөвлөгөөт ажлын хэрэгжилт, түүний үр дүн цаашид хийх ажлууд, аялал жуулчлалтай холбоотой сүүлийн үеийн мэдээ, мэдээллийг танилцуулж, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар түүний хэрэгжилтийг байгууллагын дотоод сүлжээнд тогтмол байрлуулан ажиллаж байна.
- Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг 14 хоногоор төлөвлөж, хэрэгжилтийг 14 хоног тутам мэдээлэн, дээд газрын тогтоол шийдвэрийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэн холбогдох газарт тайлан мэдээг хүргүүлж байна.
- БНХАУ-ын Аялал жуулчлалын хэрэг эрхлэх газрын дарга Ли Жин Жао 6 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд хийх албан айлчлалыг зохион байгуулах БОАЖЯ-тай хамтран бэлтгэл ажлыг хангах АСЕМ Гэр ресторанд 6-р сарын 20-ны өдөр зочдыг хүлээж авах хөтөлбөрийг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын Газрын Гадаад харилцааны хэлтэстэй хамтран зохион байгуулав. Монгол улсаас Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд, Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгалан, тус хэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Отгонсүрэн, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх, БНХАУ-аас тус улсын аялал жуулчлалын хэрэг эрхлэх газрын дарга Ли Жинзао, Гадаад хамтын ажиллагааны дарга Лиу Шижун, ерөнхий удирдлагын газрын орлогч дарга Шу Хайжун, гадаад хамтын ажиллагааны Европ Америк бүсийг хариуцсан газрын дарга Чуй кэ, ерөнхий удирдлагын газрын ажилтан Лу Кайлин, олон улсын харилцаа гадаад хамтын ажиллагааны газрын ажилтан Жао кэ, Өвөр Монголын Өөртөө Засах Орны Аялал жуулчлалын товчооны дарга Вэй Гуонан, орлогч дарга Жанг Жидонг нар оролцов. Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор БНХАУ-тай хамтран ажиллах талаар санал боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтсээр дамжуулж танилцуулсан. Тус уулзалтын үеэр Монгол үндэсний хувцасны загварын үзүүлбэр болон урлагийн тоглолт зохион байгуулав.
- Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын Аялал жуулчлалын холбоо хамтран зохион байгуулсан “Аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн чуулган-2017” арга хэмжээнд оролцов.
- Улаанбаатар хотын иргэдэд эрүүл агаар бэлэглэх аяны хүрээнд нийслэлийн хот орчимд үйл ажиллагаа явуулж буй жуулчны бааз амралтын газрын 96 байгууллагатай холбогдон зурган мэдээлэл бэлтгэн цахим сувгуудаар иргэдэд мэдээлэх талаар танилцуулга хийж, 45 байгууллага мэдээллээ ирүүлэхээр саналаа өгснөөс 26 байгууллага ирүүлж, мэдээллийг нэгтгэв.
- Үндэсний их баяр наадмын үеэр Төв цэнгэлдэх хүрээлэнгийн 3, 4, 15 дугаар сектор болон нэмэлт суудлын нийт 2500 ширхэг тасалбарыг Улаанбаатар хотод аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 79 аялал жуулчлалын компаниудад хуваарилав. Тус газрын ажилтан, албан хаагчид 2016 оны 07 дугаар сарын 11-ний өдөр эдгээр секторуудад жуулчдыг тасалбарын дагуу суулган ажиллав.
- Нийслэлийн Мэдээллийн технологийн газар, “Софтлайн Азия” ХХК-тай гурвалсан гэрээг байгуулж /Kaspersky, Endpoint Security 10/ 22 ширхэг антивирус програмын нэг жилийн хугацаатай лицензийг худалдан авч байгууллагын нийт 18 албан хаагч, зөөврийн 2 компьютерт суурилууллаа.
- МУ-ын Ерөнхийлөгчийн 2010 оны Мод тарих үндэсний өдөр зарлах тухай 63 дугаар зарлиг, Ойн тухай хуулийн дагуу “Бүх нийтийн мод тарих өдөр”-өөр тус байгууллагын албан хаагчдаас нийт 90.000 төгрөгийг Ногоон байгууламжийн санд хандивлав.
- Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээнд тус газрын албан хаагчид оролцож Дамдинсүрэнгийн гудамжийн гүүрнээс Нарны зам хүртэл цас цэвэрлэж, Сэлбэ голын баруун талын зам дагуу цэвэрлэгээ хийж нийт 8 шуудай хог ачуулж ажилласан. Нийслэлийн 378 жилийн ойг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээнд тус газрын албан хаагчид Улсын их дэлгүүрээс Улаанбаатар их дэлгүүр хүртэлх зам дагуу хашаа, хайс, шон дээр наасан зарыг хусах, унасан навч цэвэрлэж нийт 6 шуудай хол ачуулав. Уг цэвэрлэгээнд байгууллагын албан хаагчид бүрэн хамрагдсан.

- Байгууллагын дэргэдэх Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлав. Ёс зүйн хорооны хурлаас 1 ажилтанд газрын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулав.
- Төрийн албан хаагчдын 2016 оны хөдөлгөөний тайланг гарган 2017 оны 1 сарын 10-ны дотор Нийслэл дэх төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлжээ. 2017 онд сул ажлын байрыг зарлах саналаа Нийслэл дэх ТАЗ-ийн салбар зөвлөлд хүргүүлсний дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшлийн шалгалт авах ажил зохион байгуулагдаж, хуулийн дагуу хамгийн өндөр оноо авсан А.Азжаргалыг Нийслэл дэх ТАЗ-ийн салбар зөвлөлийн саналын дагуу албан тушаалд томиллоо.
- Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/198 дугаар захирамжийн дагуу Азийн зүүн бүсийн эрэгтэйчүүдийн волейболын аварга шалгаруулах тэмцээнийг 2017 оны 5 сарын 20-26-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллав.
- Монгол Улсын ерөнхий сайдын 2017 оны 52 дугаар захирамжийн дагуу тус газрын даргын 2017 оны А/166 дугаар тушаалаар “Ази, Номхон далайн бүсийн 31 дүгээр Жембори”-г 2017 оны 07 сарын 27-ноос 08 сарын 03-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан бэлтгэл ажлыг ханган ажиллав.
- БНСУ-ын Инчион хотын даргын айлчлалын үеэр төлөөлөгчдийг аялуулах аяллын хөтөлбөр боловсруулан бэлтгэж НЗДТГ-т хүргүүлэв.
- Улаанбаатар хот, Монголчуудын ёс заншил, монгол ахуйг гадаадад сурталчлах, Унгар улсын Будапешт хотноо 2017 оны 8 дугаар сард зохион байгуулагдах “Гар урчуудын баяр” арга хэмжээнд хэрэглэх иж бүрэн тавилгатай монгол гэрийн судалгаа хийж худалдан авах ажлыг зохион байгуулав.
- НЗД-ын 2017 оны А/166 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах Ажлын хэсгийн хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Ази, Номхон далайн бүсийн 31 дүгээр Жемборийн зочин, аялагчдад зориулан Монгол орны тухай 100 ширхэг сэтгүүл, видео материалын эх бэлтгэх, “UB guide” сэтгүүлийн дугаарт Жемборийн тухай 1 нүүр танилцуулгыг гаргахаар төлөвлөсөн. Арга хэмжээний үеэр Нийслэлийн Цагдаагийн газар, Монголын Оюутны Холбоотой хамтран “Tourist Guide Police-2017” арга хэмжээнд хамрагдсан 30 оюутныг Жемборийн дүрэмт хувцас, лого, тэмдгийг зүүлгэж ажиллуулав.
- НЗД-ын 2017 оны А/198 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах /Азийн зүүн бүсийн эрэгтэйчүүдийн волейболын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай/ Азийн зүүн бүсийн эрэгтэйчүүдийн волейболын аварга шалгаруулах тэмцээнд 8 улсын 180 гаруй тамирчид оролцсон. Тамирчдад Улаанбаатар хотыг танилцуулах сурталчлах зорилгоор “Монголын түүх, хөшөө дурсгал”, “Горхи-Тэрэлж дэх уулын болон морин аялал”, “Сонгодог болон шоппинг аялал” гэсэн чиглэлээр маршрут боловсруулж өгч Монголиан күүст компаниар гүйцэтгүүлэв.
- НЗД-ын 2017 оны А/167 дугаар захирамжийн дагуу Жэй Си Ай байгууллагын Ази, Номхон далайн бүсийн чуулга уулзалтыг Улаанбаатар хотод 2017 оны 06 дугаар сарын 08-11-ний өдрүүдэд зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахаар Тус газраас зохион байгуулагчдад мэргэжлийн үнэмлэхтэй хөтөч тайлбарлагчдын судалгаа, хот орчимд морь унуулдаг иргэдийн судалгаа, 42 үзмэрийг хамарсан 10 чиглэлийн хотын хагас өдрийн аяллын маршрутыг гаргаж өгөв. Мөн төлөөлөгчдөд тараах 1000ш хотын газрын зургийг хэвлүүлж ажлын хэсгийнхэнд хүлээлгэж өгөв.
- 2017 оны 4 дүгээр сард болох АНУ-ын Филадельфийн оркестр арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсгийн хуралд тус газрын дарга Д.Батсүх оролцов.
- Азийн хөгжлийн банкны төслөөр хэрэгжиж буй газар зүйн мэдээллийн системд суурилсан нийслэлийн дундын мэдээллийн санг өргөжүүлэх, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус газрын дарга Д.Батсүх орж ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд дундын мэдээллийн санг бий болгох техникийн шийдлийг тогтох хуралд Захиргааны хэлтсийн дарга Д.Ганболд, техникийн ажилтнуудын сургалтад мэргэжилтэн А.Эрдэнэцогт нар оролцлоо.
- Дэлхийн аялал жуулчлалын өдрийг тохиолдуулан Тогтвортой аялал жуулчлал–Хөгжлийн түлхүүр арга хэмжээг 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд БОАЖЯ, Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран зохион байгуулав. Арга хэмжээний үеэр Гранд тур арга хэмжээний “Спорт аялал”-ын тэмцээнд 1,2,3 дугаар байрт шалгарсан 12 оюутанг шагнаж урамшуулав.

➤ Итали улсын Соёл, аялал жуулчлалын дэд сайд Он Дорина Вианкитай хийсэн уулзалтад Нийгмийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч, нийслэлийн засаг даргын орлогч Ш.Анхмаа, тус газрын дарга Д.Батсүх нар оролцов.

➤ 2017 оны 9 дүгээр сарын 26-наас 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд Монгол-Хятадын хоёр дахь удаагийн экспо арга хэмжээ БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотноо болов. Энэхүү арга хэмжээнд Нийслэлийн Аялал жуулчлалын газрын орлогч дарга Ц.Энхтүвшин, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн З.Оюуншүр нар оролцож, арга хэмжээний үеэр зохион байгуулагдсан Хөх хот, Хэбэй мужийн Жэнжөү хот, Шанси мужийн Тайюан хотод болсон Монгол, Орос, Хятад гурван улсын “Цайны зам” бизнес аяллын сурталчилгааны танилцуулах уулзалтад оролцлоо. Мөн арга хэмжээний үеэр “Түмэн газрын цайны зам” холбоонд Нийслэлийн Аялал жуулчлалын газраас гадна Монгол улсаас Дорноговь болон Дорнод аймгуудын Аялал жуулчлалын газрууд нэгдсэн орсон болно.

➤ БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн аялал жуулчлалын танилцуулга, хамтарч ажиллах уулзалт тус газрын орлогч дарга Ц.Энхтүвшин болон ажил хариуцсан ажилтнууд оролцов.

Б. ЦАГ ҮЕИЙН АЖЛЫН ШААРДЛАГААР ДЭЭД ГАЗРААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР:

➤ Агаарын бохирдолгүй, техник технологийн шинэ дэвшлийг олон нийтэд танилцуулах, Улаанбаатар хотыг аялал жуулчлалын зорих газар болгон гадаадад сурталчлах зорилготой И-Формула олон улсын тэмцээн зохион байгуулах танилцуулга бэлтгэн Нийслэлийн Засаг даргад танилцуулав.

➤ БОАЖ-ын сайд Д.Оюунхорол 2017 оны 3 дугаар сарын 16-нд ХУД-ийн 13 хорооны иргэд, 17-нд Баянзүрх дүүргийн иргэдтэй уулзалт зохион байгуулсан. Уулзалтад тус газрын дарга Д.Батсүх ажиллав.

➤ Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо, Засгийн газар хамтран баталсан Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгалан 2017 оны 3 дугаар сарын 23-ны өдөр нийслэлийн Хангарди ордонд хэвлэл мэдээллийн байгууллагуудад танилцууллаа. Уг танилцуулгын ажилд тус газрын дарга Д.Батсүх ажиллав.

➤ Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2017 оныг “Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жил” болгон зарласан ажлын хүрээнд иргэдэд үйл ажиллагаагаа сурталчлах, мэдээлэх, төрийн үйлчилгээг ойртуулах зорилгоор нээлттэй хаалганы өдөрлөгийг 4-р сарын 24-ний өдөр Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулав. Өдөрлөгийн үеэр зочид буудал, жуулчны бааз, амралтын газрын үйл ажиллагааг эрхлэх хүсэлтэй 50 гаруй иргэд, аж ахуйн нэгжид эрх зүй, стандартын талаар зөвлөмж өгч, гарын авлага материал түгээж, жуулчны улирлын хугацаанд “Жуулчинд ээлтэй Оюутан цагдаа-2017” арга хэмжээнд оролцох сонирхолтой их, дээд сургуулийн аялал жуулчлал, олон улс, гадаад хэлний ангийн 60 гаруй оюутан бүртгэж, мэдээлэл өгч ажиллав.

➤ Аялал жуулчлалын тусгай бүс байгуулах, тусгай бүсийн эрх зүйн орчин болон шинээр бий болгох үйлчилгээний санал зэрэг танилцуулга материал бэлтгэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид танилцуулсан

В. ШИНЭЭР САНААЧИЛСАН АЖЛУУД:

- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн ажлууд:

➤ БНСУ-ын Чэжү хотын Аялал жуулчлалын газартай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу БЗД-ийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт явган аяллын 14км зам, Налайх дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт явган аяллын 11км замд нийт 120ш туузтай багана, эхлэл төгсгөл цэг дээр морь хэлбэрт 8 тэмдэг, 2.2 өндөртэй том самбар 2-ыг тус тус байрлуулж тохижуулан 2017 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Богдхан уулын ДЦГ, болон Горхи Тэрэлжийн Байгалийн цогцолборт газарт тус тус хүлээлгэн өгөв. Тохижилтын ажлыг БНСУ-ын Чэжү хотын Аялал жуулчлалын газрын хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэв.

➤ Монгол улс, ОХУ, БНХАУ-ын хамтарсан цайны зам олон улсын төслийн хүрээнд ӨМӨЗО-ны Аялал жуулчлалын газартай хамтран БЗД-ийн 12 дугаар хорооны нутаг

дэвсгэр, Дулмаалин хийдийн хашаан дотор буюу Их Хүрээний хоёр өртөөний нэг болох зүүн хэсгийн “Цайны зам”-ын худалдааны Монголд хэрэглэх цайг буулгах, бусад аймаг хошуунд хуваарилах гол зангилаа газар болж байсан, Монголоор дайрч Европ руу тээвэрлэдэг цайны 10 орчим хувь нь энэ өртөөгөөр дамжин явж байсан түүхтэй энэ газарт 1м 85см-ийн өндөртэй, 1м 50см-ийн өргөнтэй, саарал өнгийн боржин чулуун дээр түүхийг хараар товойлгон зурж, үсгийг сийлж бичиж бүтээсэн “Цайны замын хөшөө”-г БНХАУ-ын ӨМӨЗО-ны Аялал жуулчлалын газрын хөрөнгө оруулалтаар барьж байгуулав.

- Нийслэлийн хөрөнгө оруулалтаар

➤ “Шөнийн гэрэлт гудамж” төсөл хэрэгжүүлэв.

Улаанбаатар хотыг олон улсад өрсөлдөх чадвартай, зүүн хойд Азийн бизнес, соёлын болон дамжин өнгөрөх жуулчлалын төв болгон, ирсэн жуулчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрөөх аялал жуулчлалын олон талт үйлчилгээ бий болгох зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/496 дугаар захирамжийн дагуу “Шөнийн гэрэлт гудамж” төслийн төлөвлөлтийн зураг, төслийг НХТЕТГ, төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан ажиллах менежментийн багийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах ажлыг НСУГ, худалдаа, үйлчилгээнд, хяналт тавих ажлыг НМХГ гүйцэтгэн, төслийг хэрэгжүүлэгч байгууллагаар Юнайтед Инвестмент партнерс ХХК ажиллав. Тус газар Шөнийн гэрэлт гудамжинд асар болон зориулалтын бусад түр байгууламжаар худалдаа, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгжүүд, хоол үйлдвэрлэл үйлчилгээ, хүнсний худалдаа эрхлэх, бэлэг дурсгал, гар урлалын үндэсний брэнд бүтээгдэхүүний худалдаа эрхлэх чиглэлээр аж ахуйн нэгжүүдийн сонгон шалгаруулалтын ажилд оролцож, гудамжны өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан ажиллах менежментийн багт, дэмжлэг, туслалцаа үзүүлж хамтран ажиллав. Шөнийн гэрэлт гудамж 2017 оны 06 сарын 08-ны өдөр нээлтээ хийж, 09 дүгээр сарын 30-ны өдөр хааж, долоо хоногийн баасан, бямба нам гаригуудад 20:00 цагаас 05:00 цаг хүртэлх хугацаанд үйл ажиллагаа явуулж, давхардсан тоогоор 1,024,000 хүн ирсэн. Үүнээс 65 мянга гаруй нь гадаадын иргэд, жуулчид байлаа. Тус газрын зүгээс Шөнийн гэрэлт гудамж төслийн хүрээнд Гэр мэдээллийн төвийг шинээр нээж, тохижуулан, мэдээллийн ажилтанг 2 ээлжээр ажиллуулав.

➤ “Улаанбаатар” үсгэн хэлбэрт биет бэлгэ тэмдгийг байршуулав.

Нийслэлийн Засаг даргын А/770 тоот захирамж, нийслэлийн Аялал жуулчлалын газрын А/81 тоот тушаалын дагуу “Улаанбаатар” үсгэн хэлбэрт биет бэлгэ тэмдгийг Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Улсын драмын эрдмийн театрын дэргэдэх талбайд байршуулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.5 дахь заалтыг үндэслэн “Б.Ц.Х.Ц” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгэв. “Улаанбаатар” үсгэн хэлбэрт биет бэлгэ тэмдгийн суурь нь 20 см өндөр, нийт 11 үсэг байх бөгөөд U, L, B, T үсгийн өндөр 170 см, бусад үсэг 108 см байх, үсгийн нийт урт 1025 см, зузаан 50 см, суурь болон үсгүүд лед гэрэлтүүлэгтэй. Цаашид арчлалт, хамгаалалтын ажлыг Сүхбаатар дүүргийн хот тохижилтын газарт хариуцуулан хүлээлгэн өгөв.

➤ Мөсөн хотхон байгуулав.

Дэлхийн өвлийн хотуудын дарга нарын холбоо 1981 онд байгуулагдсан. Өвөл болдог хотууд нэгдэж бие биенээсээ туршлага судлах, аялал жуулчлал, хот тохижилт, хог хаягдал, агаарын бохирдол зэрэг тулгамдсан асуудлаа шийдвэрлэх, мэргэжилтнээ солилцох, сургах чиглэлээр хамтран ажилладаг энэ холбоонд Улаанбаатар хот 1998 онд элсэн орсон. Өвөл болдог хотуудын өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээний нэг нь цас мөсний баяр байдаг. Нийслэлийн Аялал жуулчлалын газраас газар өвөл болдог хотуудад жил бүр уламжлал болгон зохиогддог олон улсын цас, мөсний баярын арга хэмжээний талаар судалгаа хийж, танилцуулга бэлтгэн Нийслэлийн Засаг даргад танилцуулсан. Улаанбаатарын Мөсөн хотхон байгуулах ажлыг Захирагчийн ажлын албатай хамтран хэрэгжүүлэв.

Б/. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ТАЛААР:

Хүний нөөцийг чадавхжуулах, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийгдсэн ажлын хэрэгжилт 86 хувьтай байна. Ажилтнуудын мэдлэг боловсролыг

дээшлүүлэхээр Нийслэлийн Үйлдвэр инновацийн газраас зохион байгуулсан Мега төсөл ба төслийн санхүүжилт, төслийн гэрээ, хэлэлцээрийн үндсэн бүтэц, гэрээ байгуулахад анхаарах асуудал сэдэвт сертификаттай сургалтад 1 ажилтан, Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан 45 хоногийн Компьютерийн үндсэн хэрэглээ сэдэвт сертификаттай сургалтад 1 ажилтан, НЗДТГ-аас зохион байгуулсан Бодлогын баримт бичиг боловсруулах сургалтад 3 ажилтан, НЗДТГ, Нийслэлийн Хүүхэд гэр бүл, хөгжлийн газраас зохион байгуулсан шинээр батлагдсан хуулийг хэрэгжүүлэх, сурталчлах зорилготой Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг танилцуулах сургалтад 1 ажилтан, Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан Албан хэрэг хөтлөлтийн сургалтад архив, бичиг хэргийн эрхлэгч 3 удаа, Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар тус газартай хамтран зохион байгуулсан Гадаадын жуулчны хөтөч бэлтгэх сертификаттай сургалтад 4 албан хаагч тус тус хамрагдав. Албан хаагчдыг Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан Албан хэрэг хөтлөлтийн сургалтад нийт 18 албан хаагч, Монгол улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврын хүрээнд 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Төрийн албаны зөвлөлийн ахлах референт Зоригтбаатар Төрийн албан хаагчийн ёс зүй, Үр дүнгийн гэрээ байгуулах талаар сургалтад нийт 21 албан хаагч, БОАЖЯ-тай хамтран зохион байгуулсан Дэлхийн Аялал жуулчлалын байгууллагын зөвлөх, эксперт Стэфэн Ноакийн “Тогтвортой аялал жуулчлал, тогтвортой хөгжлийн зорилт 2030-д аялал жуулчлалын салбарын оруулах хувь нэмэр” сертификаттай сургалтад нийт 17 албан хаагч хамрагдаж, 3 ажилтан мэргэжлээ дээшлүүлэн магистр болон бакалаврын зэрэг олгох сургалтад суралцаж байна. НЗДТГ, БНСУ-ын Пусан хотын захиргаанаас нутгийн засаг, захиргааны байгууллагуудыг ажилтнуудын “К2Н” солилцооны 6 сарын хөтөлбөрт 1 ажилтанг хамруулж, БНСУ-ын Чезү хотын Аялал жуулчлалын газраас зохион байгуулсан 7 хоногийн сургалтад 1 ажилтанг хамруулав. Тус газрын ажилтнуудын 70 хувь нь 3 дээш ажиллаж байгаа албан хаагч байна. Албан хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажлын хэрэгцээний компьютер техник хэрэгсэл, бичгийн хэрэгслээр хангаж, шинээр ажилд орсон ажилтнуудад хууль тогтоомж, дүрэм, журмыг танилцуулж, мэдээллээр ханган ажиллав. Нийслэлийн Засаг даргын 2017 оны Зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай А/171 дүгээр захирамжийн дагуу тус газрын даргын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн Б/18 дугаар тушаалаар нийт 3 албан хаагчдад зэрэг дэвийн нэмэгдлийг шинэчлэн, 1 ажилтан ур чадварын нэмэгдэл олгов. Ажилтнуудын судалгааг гарган дээд газарт ажлын байдлын тодорхойлолт хүргүүлж, Захиргааны хэлтсийн дарга Д.Ганболдыг Хөдөлмөрийн хүндэт медаль, Орлогч дарга Ц.Энхтүвшинг “Хөдөлмөрийн гавьяаны удаан тугийн одон”-гоор тус тус шагнуулав. Шинээр хүүхэд төрүүлж, жирэмсний амралтаа эдэлж байгаа нийт 5 албан хаагчид 1.200.000 төгрөг, Төрийн одон медаль авсан 2 албан хаагчид 480.000 төгрөг. Шинээр гэр бүл болж хуримаа хийсэн 1 албан хаагчид 720.000 төгрөгийг олгож мөнгөн урамшуулал олгов. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан нийт 13 албан хаагчийн 21 хүүхдэд 420.000 төгрөгийн бэлгийг дурсгалын зүйл гардуулав. Нийслэлийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 18 ажилтан хамрагдав.

VI. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААР

Тус газрын 2016 оны үйл ажиллагаанд НЗДТГ-ын Шалган зааварлах ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган ажиллаж, 22 заалтын хэрэгжилт 95 хувьтай ханган ажиллав.

Г/. ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

Тус газарт 2017 онд нийт 29 өргөдөл ирсэн байна.

Үзүүлэлт	2017.01.01-03.24		2017.03.25-06.24		2017.06.25-09.24		2017.09.25-12.24	
	Ирсэн тоо	Хувь	Ирсэн тоо	Хувь	Ирсэн тоо	Хувь	Ирсэн тоо	Хувь
Ирсэн өргөдлийн тоо	6	100%	11	100%	7	100%	5	100%

- Үүнээс 1800-1200 тусгай дугаарын утсаар 2 гомдол, санал, www.ub1200.mn цахим хуудсаар 2 хүсэлт, Засгийн газрын 11-11 төвөөр 6 гомдол, Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөр 1 хамтран ажиллах тухай санал, 3 өргөдөл болон тус газарт боловсон хүчинтэй холбоотой 15 хүсэлт ирсэн байна. Тайлангийн хугацаанд 6 мэргэжилтэн 29-н өргөдлийг хугацаанд нь 100% шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэх шатандаа судлагдаж байгаа өргөдөл, гомдол байхгүй байна. Мөн газрын даргад өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар сар тутамд тайлан гарган танилцуулж ажиллаж байна. Энэ хугацаанд хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл байхгүй болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Байгууллагын ил тод байдлын хэрэгжилт:

Байгууллагын ил тод байдлын төлөвлөгөөний биелэлт 2 зорилт 14 заалтын хэрэгжилт 89 хувьтай ханган ажиллав. Үүнд:

Д.Сүхбаатарын талбайд БОАЖЯ, НЗДТГ-аас зохион байгуулсан Нээлттэй хаалганы өдөрлөг, Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн Дүнжингарав салбарт хүний нөөцийн нээлттэй өдөрлөгт тус тус оролцож, 190 гаруй иргэнд тус газраас үзүүлэх үйлчилгээний талаар танилцуулга, мэдээлэл хийж, ажлаа сурталчлав.

Байгууллагын ub.tourism.gov.mn цахим хуудаст үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл:

-Байгууллагын танилцуулга, эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, хэрэгжүүлсэн арга хэмжээ, бүтцийн схем, ажилтнуудын мэдээлэл, үйлчилгээтэй холбоотой мэдээлэл, дүрэм журам, мэдээ мэдээллийг байршуулсан.

- Ил тод байдлын хүний нөөцийн цэст: Албан хаагчдын шинэчилсэн ажлын байрны тодорхойлолт, Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрэм, Авлигын эсрэг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, ажилтнуудын ажлын байрны нэр, албан тушаал, утасны дугаарыг ил тод байршуулав.

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

- Чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр:

Нийслэл хотын зочид буудал, дэн буудлуудын үйлчилгээний чанар, ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, жуулчдын аюулгүй байдлыг хангах, зочлох үйлчилгээний салбарын эрхлэгч, менежер, ажилтнууд, жуулчидтай шууд харилцдаг төрийн байгууллагын ажилтнуудад зориулж үйлчилгээний чанар, стандарт, аюулгүй байдал, харилцааны соёл, хөтөч-тайлбарлагчийн зэрэг сургалтуудыг зохион байгуулах болон тус газраас жуулчдад зориулсан аялал жуулчлал, спорт, соёл урлагийн арга хэмжээг аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын төлөөлөл бүхий хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх үүднээс 5 төр болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулж, 103 хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллав.

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан ажлын талаарх:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын хэрэгжилтийг хангах, үйлчилгээг сайжруулах, шуурхай болгохоор албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлж уг асуудлыг хавсран хариуцдаг 2 ажилтан нэмсэн. Эдгээр албан хаагчид иргэд, ААН-ээс зочид буудал, дэн буудал, амралтын газрын зөвшөөрөл хүссэн өргөдлийн дагуу ажлын хэсэг стандартын үзлэг шалгалтыг санал хүсэлт ирснээс хойш 9 хоногт багтаан шийдвэрлэхийг зорилтоо болгон ажиллаж байна.

ТАНИЛЦСАН: ДАРГА

Д.БАТСҮХ

ХЯНАСАН: БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ТУЛГАА

БОЛОВСРУУЛСАН: МЭРГЭЖИЛТЭН

Э.МӨНХЗУЛ